



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Соёл урлагийн их сургууль, Хөгжмийн урлагийн сургууль

Сургалтын хөтөлбөрийн нэр: Багш, урлагийн боловсрол /хөгжмийн/

Индекс: D011404

2018 оны 5 дугаар сарын 24, 25

Агуулга

Хуудас

Товчилсон үгийн тайлбар

I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт	4
II. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	5
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт.	6
Шалгуур 2: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл.....	10
Шалгуур 3: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт.....	17
Шалгуур 4: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа.....	25
Шалгуур 5: Багшийн үйл ажиллагаа.....	33
Шалгуур 6: Сургалтын үйл ажиллагаа.....	38
Шалгуур 7: Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө.....	44
Шалгуур 8: Чанарын үнэлгээ, баталгаажилт.....	49
V. Оролцогчдын нэрс	
I. Ярилцлагад оролцсон багш нарын нэрс.....	54
II. Оюутны нэр.....	54
III. Ажил олгогч.....	55
IV. Төгсөгчид.....	55
VI. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал.....	56
YII. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	
YIII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	

Товчилсон үгийн тайлбар

- БУБ – Багш, урлагийн боловсрол
- ХУС – Хөгжмийн урлагийн сургууль
- СӨБ – Сургуулийн өмнөх боловсрол
- ЕБС – Ерөнхий боловсролын сургууль
- СХУ –
- ОХУ – Оросын Холбооны Улс
- МУБИС – Монгол улсын боловсролын их сургууль

I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Соёл урлагийн их сургууль, Хөгжмийн урлагийн сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Багш, урлагийн боловсрол	
Индекс	D011404	
Шинжээчид	<p>Ахлагчийн нэр, ажил, албан тушаал: 1. Б.Одончимэг - боловсрол судлаач</p> <p>Гишүүдийн нэр, ажил, албан тушаал: 2. Ц.Шаравцэрэн – Монгол улсын консерваторийн сургалт эрхэлсэн дэд захирал 3. Т.Олоннэмэх-НБГ-ын үндэсний болон дэд хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн</p>	
БМИҮЗ-ийн зохицуулагч	Зохицуулагчийн нэр, албан тушаал: Б.Мядагмаа Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хариуцсан ахлах мэргэжилтэн	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Зохицуулагчийн гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	Шинжээчийн ажиллах хуваарийг хавсралтаар оруулав	

ШАЛГУУР 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Үзүүлэлт нотолгоо:

1.1.1. Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийсэн байдал

Тайлантай танилцахад: “Тогтвортой хөгжлийн боловсрол-2030” болон бусад баримт бичгүүдийг судалж, дэлхийн боловсролын хөгжлийн чиг хандлага болон орчин үед бие хүний төлөвшилд урлагийн боловсролын үзүүлэх нөлөөг тодорхойлсон байна. Хөгжмийн багшийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаагаар 2016-2017 оны хичээлийн жилд СӨБ, ЕБС-д хөгжмийн багшийн хангалт 57,7%-тай байгаа ¹ тооцоог тусгажээ.

Бодит байдалтай танилцахад: БУБ хөтөлбөрийн Хөгжмийн багш чиглэлээр хийсэн эрэлт нийлүүлэлтийн судалгааны асуулга, нэгтгэл, дүгнэлтүүд хавсралтаар байршсан байлаа.

Уулзалтаар: ХУС-ийн захирал Ганцэцэгийн бэлтгэсэн танилцуулгад мэргэжлийн бус багшийн эзлэх хувийг бууруулж, мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, мэргэшүүлэх, ажлын байранд тасралтгүй суралцуулах зэргээр эрэлт хэрэгцээг хангахаар ажиллаж байгааг дурдсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага: Тухайн хөтөлбөрийн түүхэн хөгжлийн явц дахь улс орны нийгэм эдийн засгийн байдалтай урлагийн боловсролын чиг хандлага хэрхэн хувьсан өөрчлөгдөж, хөгжиж ирснийг уялдаа холбоонд нь судалж, дүгнэсэн байна. Ялангуяа хөтөлбөрийн 3 удаагийн шинэчлэлийн учир шалтгаан, эрэлт хэрэгцээг оновчтой тодорхойлсон байна.²

1.1.2. Төгсөгчийн /мэргэжилтний/ загвар

Тайлантай танилцахад: СӨБ, ЕБС-ийн хөгжмийн багш мэргэжлийн тодорхойлолт, мэргэжилтэнд тавих шаардлага, төгсөгчийн мөшгөх судалгаанд үндэслэн төгсөгчийн загварыг тодорхойлсон байна.

Бодит байдалтай танилцахад:

2015-2016 онуудад СУИС-ийн хөтөлбөрийн дэд хороо, хөтөлбөрийн ерөнхий хороо, Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн баталсан “Багш, урлагийн боловсрол” бакалаврын сургалтын хөтөлбөрийн сургалтын баримт бичигт хөтөлбөрийн боловсролын зорилго

¹1212mn статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас ишилсэн.

² Өөрийн үнэлгээний тайлангийн 11-13 тал

зорилтуудыг /PEO/ тодорхойлж, хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалтыг /PLO/ академик чадамж, хувь хүний чадамж, СХУ-ны чадамж, мэргэшлийн чадамжийн³ хүрээнд гаргасан байна. Судлагдахууны багц цагийн бүрэлдэхүүний чиглэлийн хувь хэмжээг нийтлэг шаардлагаас +- 4 пунктын зөрүүтэй боловсруулсан байна.

Уулзалтаар: Сурган, сэтгэл зүйн тэнхмийн эрхлэгч С.Баасандулам, зөвлөх багш Ч.Оюунбилэг нар хөгжмийн багшийн бие хүний мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлохдоо орчин үеийн хөгжмийн боловсролын чиг хандлагад нийцүүлсэн тухай тайлбарлав.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж: Цаашид хөтөлбөрөөр төгсөгчийн загварыг судлагдахууны буюу хичээлийн хүрэх үр дүнгүүдийг /CLO-Course learning outcomes/, хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй /PLO-program learning outcomes/ уялдуулан тодорхойлох шаардлагатай. Ингэснээр хөтөлбөрийн хүрэх үр дүн хэмжигдэхүйц тодорхойлогдох боломжтой.

1.1.3. Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар, чиглэлийн гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан байдал /ялгаатай, давуу, сул тал, сайжруулалт/

Тайлантай танилцахад: Дотоодын их дээд сургуулиудаас МУБИС-ийн Урлаг, Биеийн тамирын сургуулийн БУБ хөтөлбөрт харьцуулсан судалгаа хийж, БШУ-ны сайдын 2014 оны 04 сарын 28 өдрийн А/71 тоот тушаалаар батлагдсан “Дээд боловсролын бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ын дагуу анализ хийж, дүгнэлт гаргажээ. Энэ судалгаагаар СУИС-127 багц цаг, МУБИС-119 багц цаг судалж байгааг тодорхойлжээ.

Гадаадын их дээд сургуулиудаас АНУ-ын Берклийн хөгжмийн сургууль, ОХУ-ын Уралын хөгжмийн дээд сургууль, Австрийн Universitat Mozarteum Salzburg сургуулиудын ижил төстэй хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөн дэх судлагдахууны бүтэцтэй харьцуулан судалж, дүгнэлт хийсэн байна.

Бодит байдалтай танилцахад: Хөтөлбөрийн харьцуулсан судалгааны ажлын тайлан, дүгнэлт, хэлэлцүүлгийн материалуудыг хавсралтаар бэлтгэж танилцуулсан. 2011 оноос “Хөгжмийн боловсрол, сургалтын төв”-ийг байгуулан ажиллуулсан үр дүнг мөн танилцуулав.

Уулзалтаар: Судалгаан дээр ажилласан багш нар өөрсдийн хөтөлбөрийн давуу талыг тодорхойлохдоо багш мэргэжлийн чиглэлийн судлагдахууныг түлхүү тусгаж, бүх нийтийн хөгжмийн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хангалттай агуулга судлаж байгаа хэмээн үзэж байна. Элсэгчдийн хөгжмийн ур чадварын шалгуур хөгжмийн мэргэжлийн хөтөлбөртэй харьцуулахад энгийн түвшинд байдаг ч төгсөхдөө хөгжмийн багшийн түвшинд хангалттай эзэмшдэг хэмээв.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж: Цаашид ижил төстэй хөтөлбөрийн агуулга, арга зүйн харьцуулалтыг хийж, хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх талаар судлахыг зөвлөмжилж байна.

1.2 Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго

Хөтөлбөрийн үзэл баримтлал тодорхой; төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага нь мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.

³ “Багш, урлагийн боловсрол” бакалаврын сургалтын хөтөлбөр, №1, 2016 он

Үзүүлэлт нотолгоо:

1.2.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримталж байгаа үзэл баримтлал, сургалтын арга зүй, тогтсон үнэлгээний систем

Тайлантай танилцахад: Үр дүнд баримжаалсан, цогц чадамжид суурилсан өмнөх уламжлалаа баяжуулсан байдлаар хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон хэмээн дүгнэжээ.

Тайланд үйлийн явцад мэдлэг бүтээх /конструктивист онол/, суралцагчийн орчныг өөрчлөх замаар бие хүнийг өөрчлөх /бихевиорист онол/ үзэл баримтлалыг баримжаалан мэргэжлийн тодорхойлолт, судлах агуулгын томьёолол, цагийн багтаамж зэргийг боловсруулдаг тухай тусгажээ.

Сургалтын арга зүйн хувьд шинжлэх ухааны салбаруудыг интеграцчилж, байгал, нийгэм, хүмүүнлэгийн ухааны онолын дотоод холбоот тогтолцоонд нь нэгдмэл багцалсан мэдлэг бүтээлгэх, бодит орчинд багшлахуйн чадвар эзэмшүүлэх, бакалаврын бичвэрийн ажлаар дамжуулан судалгааны арга зүйд суралцуулах хэлбэрийг сонгосон байна. Тухайлбал, үйлийн судалгааны үндсэн дээр үйлийн явцдаа хөгжихүйн арга ажиллагааг хэрэгжүүлж байгааг тэмдэглэсэн байна.

Тогтсон үнэлгээний системийн тухайд орц, явц, гарцын үнэлгээтэй холбоотой мэдээлэл цуглуулах, мэдээлэлд үндэслэн дүгнэлт өгөх зэргээр ажилладагаа дурджээ.

Бодит байдалтай танилцахад: Хөгжмийн суурь ухааны судлагдахууныг бодит чадварын үйлдэлд суурилсан арга барилаар зохион байгуулдаг байна. Тухайлбал, ганцаарчилсан хөгжмийн бэлтгэл, найрал дуу удирдах, соноршуулга, зохиролын ухаан зэрэг судлагдахууныг оюутнууд бодит үйлдлээр судалж суралцаж байв. Боловсрол судлал, багшлахуйн арга зүйн судлагдахууныг ээлжит хичээлийн явцад “мини хичээл”, “үзүүлэх хичээл” зэрэг арга хэлбэрээр багийн зохион байгуулалтаар судалж хэвшсэн нь үйлийн явцдаа суралцах арга зүйн илэрхийлэл юм.

Уулзалтаар: 2018 оны 4 сарын 24-ны өдрийн профессор, багш нартай уулзсан уулзалтаар хөгжмийн багш мэргэжил нь хөгжимдөх, дуулах, удирдах, найруулах, судлах, сурган хүмүүжүүлэх зэрэг цогц мэдлэг, ур чадварыг шаарддаг тул ганцаарчилсан сургалтын арга барилыг түлхүү хэрэглэдэгийг дурдав.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.2.2. Хөтөлбөрийн хүрэх үр дүн, онцлог, сургуулийн эрхэм зорилго, зорилттой нийцсэн байдал

Тайлантай танилцахад: тайланд СУИС-ийн эрхэм зорилго, ХУС-ийн эрхэм зорилго, хөтөлбөрийн зорилгуудыг хүснэгтлэн харилцан хамааралтайгаар төлөвлөсөн гэдгээ тэмдэглэсэн байна. Хөтөлбөрийн онцлогийг “БУБ хөтөлбөрийн агуулга нь бусад хөтөлбөртэй харьцуулахад баялаг олон талт нэгдмэл агуулгыг хангаж байхыг шаарддаг” гэж авч үзсэн байна.

Бодит байдалтай танилцахад: 2014 онд боловсруулан баталгаажуулсан “Бакалаврын сургалтын хөтөлбөр”-ийн 2.3-т сургуулийн эрхэм зорилгыг хөтөлбөрийн зорилго, зорилтуудтай уялдуулан боловсруулсан байна.

Уулзалтаар: Сургалт хариуцсан дэд захирал, багш нар хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд хөтөлбөрийн хүрэх үр дүнг сургуулийнхаа эрхэм зорилго, зорилттой нийцүүлэх талаар олон удаагийн хэлэлцүүлэг хийж, матриц боловсруулсан талаар танилцуулав.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.2.3. Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч талуудын саналыг тусгаж, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулсан байдал

Тайлантай танилцахад: 2012 оноос эхлэн хөтөлбөрийн шинэчлэл хийх зорилгоор боловсруулсан баримт бичгүүдээ Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Боловсролын хүрээлэн, Нийслэлийн боловсролын газар, Ерөнхий боловсролын сургууль, Соёлын орднууд зэрэг 10 гаруй байгууллагаас санал авч хөтөлбөрийн боловсруулалтад тусгаснаа тайлангажээ.⁴

Бодит байдалтай танилцахад: Ажил олгогч буюу ЕБС, цэцэрлэгийн эрхлэгч, дадлага удирдсан багш нар төгсөгчдийн уулзалтын тэмдэглэлүүд, санал асуулгын тайлангуудыг эмхэтгэснээ танилцуулав. Тэмдэглэлээс харахад хичээлийн хөтөлбөр боловсруулах, бичиг баримт хөтлөх, сургалтын арга зүй боловсруулах, суралцагчийн ахиц, хөтөлбөрөө, өөрийгөө үнэлэх чадвар, бие дааж хөгжих чадвар, харилцааны чадвар, сурагчидтай ажиллах чадвар, судлан шинжлэх арга барил, удирдаачийн ур чадвар, хөрвүүлэх, найруулах чадвар зэргийг саналаас авч тусгасан байна.

Уулзалтаар: 2018 оны 5 сарын 02-ний өдөр 127 дугаар сургуулийн захирал Хүрэлбаатар, Олон улсын ардан урлагийн байгууллагын Ази хариуцсан захирал Мөнхнасан, “Шинэ үе” сургуулийн дэд захирал Цэрэндолгор, 104 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Байгаль, “Шинэ эрин” сургуулийн захирал Амартүвшин зэрэг ажил олгогчидтой уулзахад тус хөтөлбөрийн төгсөгчийн эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлоход хувь хүний чадамж, сурган хүмүүжүүлэх ухааны чадамж, мэргэжлийн чадамжийн талаар санал өгч, хөтөлбөрт тусгуулсан талаар мэдээлэл өгөв.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.3 Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга; сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй; сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган сайжруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

1.3.1. Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж, баталгаажуулсан байдал

Тайлантай танилцахад: 2014 оны 07 сарын 04-ны өдөр 011404 индекстэй “Багш, урлагийн боловсрол” хөтөлбөрийг боловсруулж, 2014-2015 оны хичээлийн жилээс мөрдөж эхэлсэн. 2016 онд сайжруулалт хийсэн.

Хөтөлбөрийн агуулгыг Багш боловсролын багц, Хөгжмийн ухааны багц, Найрал дуу, удирдаачийн ур чадварын багц, Хөгжимдөх ур чадварын багц, Ерөнхий суурийн багц гэсэн ангиллаар боловсруулсан байна. Үүнээс багш боловсролын агуулга 2011 оны хөтөлбөрт 26 кредит буюу 19,8 хувь байсан бол 2014 оны хөтөлбөрт 39 кредит буюу 30,7 хувийг эзэлсэн нь төгсөгчийн эзэмших ур чадварыг сайжруулахад чиглэсэн дорвитой алхам болсон гэж дүгнэжээ.

Бодит байдалтай танилцахад: “Багш, урлагийн боловсрол” бакалаврын хөтөлбөрийн албажуулалт нь 15/12/22 –нд Хөтөлбөрийн Дэд хороогоор, 16/1/15-нд Хөтөлбөрийн

⁴ Магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлангийн 22 дугаар нүүр, 2018 он

Ерөнхий хороогоор, 16/6/22-нд СУИС-ийн Эрдмийн Зөвлөлөөр тус тус хэлэлцүүлж, их сургуулийн захирлаар батлуулсан байна.

Мөн СУИС-ийн Хөтөлбөрийн Ерөнхий хорооны даргын албажуулсан “Сургалтын хөтөлбөрийг боловсруулах ажлын удирдамж загвар”-тай бөгөөд энэхүү загвар нь БШУ-ны сайдын 2014/4/28-ны өдрийн “Нийтлэг шаардлага батлах тухай” А/174 тушаалд үндэслэсэн байна.

Хөтөлбөрийн судлагдахууны агуулга нь ерөнхий суурь хичээл 26,7 хувь, мэргэжлийн суурь хичээл 29,9 хувь, мэргэжлийн хичээл 29,1 хувь, дадлага 10,2 хувь, дипломын ажил 3,9 хувийг тус тус эзлэхээр төлөвлөгджээ.

Уулзалтаар: Багш мэргэжлийн удиртгал хичээлийн агуулгыг заавал судлуулахаар тусгасан. Мэргэжлийн сонголт, боловсролын хууль тогтоомж, дуу хөгжмийн хичээлийн ач холбогдлын талаар түлхүү заадаг. 5 бүрэлдэхүүнд үйлийн тогтолцооны аргыг хэрэгжүүлж байгаа талаар танилцуулав.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага: Хөтөлбөрийн зорилго, боловсролын зорилтууд /PEO/, хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалтууд /PLO/-ыг матрицийн аргаар боловсруулсан байна.

Зөвлөмж: Ерөнхий суурь багцын зарим хичээлүүдийг 2 кредитийн агуулгатай төлөвлөх, “Урлагаар засахуй” болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчидтай ажиллах арга зүйн хичээлүүдийг төлөвлөлтөнд тусгахыг зөвлөмжилж байна.

1.3.2. Сургалтын төлөвлөлт нь онол, практикийг зохистой хослуулсан, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн байдал

Тайлантай танилцахад: 1970,1992 оны хөтөлбөртэй харьцуулахад 2014 оны хөтөлбөрт лекцийн хичээл нийт багц цагийн 23 хувь, семинар, практик хичээл 66,3 хувь, ганцаарчилсан хичээл 10,7 хувийг тус тус эзэлж байна. Хөгжмийн багш мэргэжил нь дуулах, хөгжимдөх, удирдах, найруулах зэрэг урлагийн мэргэжлийн олон талт ур чадварыг шаарддаг тул ганцаарчилсан хичээл чухал үүрэгтэйг дурдсан байна. 2014 оны хөтөлбөрийн 44,5 кредит нь онол, 82,5 кредит нь практик хичээлүүдээс бүрдэж байгааг диаграммаар харуулсан. Мөн дадлагын хувьд төрлийн дадлагыг 13 кредитээр гүйцэтгэхээр нэмэгдүүлсэн байна.

Бодит байдалтай танилцахад: “Багш, урлагийн боловсрол” хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичигт сургалтын төлөвлөгөөний кредитийн хуваарилалтыг тооцоолон оруулж, дадлагын ажлын удирдамжийг “Танилцах дадлага”, “Туршин заах дадлага”, “Багшлах дадлага бага боловсрол”, “Багшлах дадлага суурь боловсрол” зэрэг хэлбэр тус бүрээр боловсруулсан байна.

Уулзалтаар: Багш нар ганцаарчилсан болон семинарын хэлбэрээр илүү олон цагийн хичээл заадаг. Хөгжимдөх ур чадвар, найрал дуу, найрал хөгжмийн ур чадвар олгохдоо ганцаарчилсан эсвэл жижиг бүлгээр хичээллэдэг. Мөн нэгж хичээл, ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах, хичээлээс гадуур клуб ажиллуулах, хөгжөөн баясгах ажил зохион байгуулах зэрэг багшлах ур чадвар олгохдоо бичил хичээлийн арга зүйг ашигладаг талаар санал солилцов.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага: Ганцаарчилсан болон бага бүлгээр ур чадвар олгох хичээлийг оновчтой төлөвлөдөг.

1.3.3. Хичээлийн хөтөлбөр нь хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга, хэлбэрийг тусгасан байдал

Тайлантай танилцахад: Багш, урлагийн боловсрол хөтөлбөрийн хичээлийн хөтөлбөрийг боловсруулахдаа тухайн судлагдахуунаар эзэмших мэдлэг, чадварыг жагсаан үр дүнд суурилсан байхаар агуулга, арга зүйгээ сонгодог. Хичээл хоорондын уялдаа залгамж холбоог кодоор илэрхийлж, окуутанд санал болгох төлөвлөгөөнд тодорхой тусган хэрэгжүүлдэг тухай дурджээ.

Хичээл бүрийн төлөвлөлтөд суралцагчийн эзэмших аливаа ухагдахуун, зүй тогтол, онол, дүрмийг шинжлэх ухааны үндэстэй, нотолгоотой тусгаж, бичил хичээлийн арга зүйг ашигладаг. Бичил хичээл нь өргөн агуулгыг богино хугацаанд жижиг хэсгүүдээр бие биедээ түгээх зорилготой хичээл доторх хичээл бөгөөд багш мэргэжлээр суралцагчдад үр дүнгээ өгч байна.

Үнэлгээний хувьд оношлох үнэлгээ, явцын үнэлгээ, эцсийн үнэлгээ зэргийг шалгуурт суурилсан, гүйцэтгэлд суурилсан хэлбэрээр зохион байгуулдаг тухай дурджээ. Үнэлгээний олон хувилбарт бодлого, дасгал, тест, урын сангуудыг ашигладаг хэмээжээ.

Бодит байдалтай танилцахад: “Багш урлагийн боловсрол” хөтөлбөрийн хичээлийн төлөвлөгөөнд хичээлүүдийг кодлож, агуулгын гүнзгийрэлтийг тодорхойлсон байна. Хөтөлбөрийн 4.3-т Сургалтын төлөвлөгөөний хичээл хоорондын холбоосыг схемээр харуулсан flowchart хийж хавсаргажээ. Хөгжмийн зохиолчдын бүтээлээр урын сан бүрдүүлж, эмхэтгэл гарын авлага гаргасан байх бөгөөд Sibelius программд хөрвүүлэн цахим хэрэглэгдэхүүн болгон ашиглаж байна.

Уулзалтаар: Хөгжмийн сургалтын арга зүй хичээлээр Германы хөгжмийн мэргэжилтнүүдийн хөдөлгөөнд суурилах зарчим, АНУ-ын Kindermusik систем арга, хөгжимчин Шинчи Сузуки, Монтессори нарын боловсруулсан дэвшилтэт арга зүйг дадлагын үеэр туршиж эзэмшдэг тухай санал солилцов.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж: Судлагдахууны багц цагийн бүрэлдэхүүний мэргэжлийн суурь болон мэргэжлийн чиглэлийн хувь хэмжээг оновчтой тодорхойлох, нэгдүгээр курсэд судлах 100 гэсэн кодтой M.IE106, M.IE107 зэрэг хичээлүүдийн залгамж чанарыг хангах, хичээлийн англи нэршил, түүний товчлолыг оновчлох шаардлагатай.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН.

ШАЛГУУР 2. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн эсэхэд дүгнэлт хийх

2.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

2.1.1. Эрүүл, аюулгүй, тохилог орчинг бүрдүүлсэн байдал

Тайлантай танилцахад: Мэргэжлийн суурь хичээл, мэргэшүүлэх хичээлүүд явагддаг ба ганцаарчилсан хичээлийн 12 танхим, оюутан театр, концертын бага заал, найрал хөгжим, төрөлжсөн чуулгын хичээлийн урлагийн заал, мэргэжлийн суурь хичээлийн дэд бүлэг, бүлэг хэлбэрээр хичээллэх анги танхимууд, дуу хөгжмийн бичлэгийн студи, хөгжмийн лаборатори-урлагийн номын сан, оюутны хөгжил төв зэрэг нь оюутны бие даах болон хамтран ажиллах орчин нөхцөл бүрдсэн.

БУБ ерөнхий суурь-11, мэргэжлийн суурь-10, мэргэшүүлэх 7, нийт 28 анги танхимтай.

Дотуур байранд орон нутгаас 197 оюутан суралцаж байна. Нэг өрөөнд 2-6 амьдардаг. Нэг оюутанд 3,5-6,0 м² талбай ногдож байна. Дотуур байранд 50 оюутан тутамд 1 ариун цэврийн өрөө, мөн 72 ширхэг хөргөгч, цэвэр усны өрөө давхар бүрт байдаг. Ариун цэврийн өрөө 9, суултуур 31, угаалтуур 22 ашигладаг.

Сургалтын орчин, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулахад 42,175,000₮ зарцуулсан.

Бодит байдалтай танилцахад: ХУС-ийн 19, БУБ-ын 13 оюутан дотуур байранд амьдардаг. Анги танхимын хүрэлцээ муутайгаас 3 багш нэг ангид хичээллэдэг.

Хичээлийн байр сүүлийн 3 жилд ерөнхий суурь хичээлийн танхимын хүрэлцээ сайжирсан, ганцаарчилсан хичээлийн анги танхимын хүрэлцээ багассан.

Уулзалтаар: БУБ-ын 1-р курсын оюутан Л.Ариунжаргал Баянхонгороос Бадмаараг ахлах сургуульд 3 жил сурч, СУИС-д элсэн суралцаж байгаа. Дотуур байр⁵ны орчин, хичээл давтах, амрах орчин бүрдэж чадсан. Номын сан, бялдаржуулах, ширээний теннисний өрөөтэй тул оюутнууд тогтмол үйлчлүүлдэг.

БУБ-ын 1-4 дүгээр курсын оюутнууд сургуулиас нэмэлтээр гаргасан хуваарийн дагуу ирж ганцаарчилсан хичээлээ давтдаг.

Дүгнэлт: СУИС-ийн БУБ-ын суралцагсдын хичээлийн байрны сурах сургах орчин, оюутны дотуур байрны тохижилт, эрүүл аюулгүй амьдрах таатай орчинг бүрдүүлж чадсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Нэг багшид ногдох талбай 4,0м² байхаас 4,0м², нэг багшид ногдох компьютер 1 байхаас 1 байна.
- “Оюутан театр”-т оюутнуудыг мэргэжлийн тайзан дээр бэлтгэж байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй оюутанд зориулсан зориулалтын суултуур зам, шат, орц гарцын тэмдэг тэмдэглэгээтэй.
- Сургуулийн давхар бүрт ус цэвэршүүлэгч байршуулсан.
- Гал унтраах хэрэгслүүд, дохиоллын систем, хамгаалалтыг бүрэн хийсэн.

Анхаарах асуудал:

- Лабораторийн нэг суудалд ногдох талбай дээд боловсролын байгууллагад тавигдах стандартад зааснаар 2,5м² байх ёстойгоос хөтөлбөрт хамаарах үзүүлэлт 1,3м² байгаа нь 1,2м²-ээр, бүх төрлийн лекцийн нэг суудалд ногдох талбай 2,2 м² байх ёстойгоос 1,7м² байгаа нь 0,5 м²-ээр тус тус дутаж байна.⁶
- Ганцаарчилсан хичээлийн анги танхимын хүрэлцээ муутайгаас 3 багш нэг ангид хичээллэдэг.

⁵ Монгол Улсын дотуур байрны ерөнхий шаардлага MNS 5869:2008

⁶ БСШУ-ы сайдын 2013 оны 217 тоот тушаал “Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага байгуулах, шинэ мэргэжлээр сургалт эрхлэх, шинэчлэхэд баримтлах нийтлэг шаардлага”

- СУИС-ийн I байрны анги танхимын хүрэлцээ хангалтгүйгээс оюутнуудыг өглөө 07:40-09:00, 21:00-23:00 цаг хүртэл хуваарийг гаргаж давтлага хийлгэж байна.

Зөвлөмж: Ерөнхий төгөлдөр хуурын хичээлийн давтлага хийх анги танхимын хүрэлцээг дэд бүлгээр хичээллэх орчинг бүрдүүлэх талаар АНУ-ын “Music education” /“Хөгжмийн боловсрол”/ хөтөлбөрийг судалж, жишиг авах боломжийг судлах

2.1.2. Тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, лаборатори, урлангийн хангалт, ашиглалтын байдал

Тайлантай танилцахад: 2013 онд Intel /R/ Core (Т.М) i3-4130 хүчин чадлын 22ш процессор, 2014 онд 25ш чихэвч, Victor digital viewer AV-P1000 томруулагчийг сургалтад ашиглаж, тоног төхөөрөмжөө сайжруулсан.

Цөөхүүл чуулга, найрал хөгжмийн зэмсгийн хэрэглэгдэхүүнээс 4 ёочин, 6 ятга, 2 их хуур, 2 ЯМАНА жижиг бөмбөр, цан хэнгэрэг, 1 хуучиртай.

Сүүлийн 5 жилд “Багш урлагийн боловсрол”-ын багш нар зөөврийн компьютер 9, суурин компьютер 5, хөтөлбөрийн сургалтад шаардлагатай хөгжмийн зэмсэг, зургийн аппарат, видео камер, проектор, систем хөгжим, хувилагч машин, электрон самбар зэрэг 2 зэрэг тоног төхөөрөмжүүдийг худалдан авч сургалтад хэрэглэж байна.

Нийтийн эзэмшлийн талбайд оюутны хэрэгцээнд зориулж интернэт холболт бүхий 3 компьютер, цахим дэлгэц олшруулагч машин байршуулсан.

Бодит байдалтай танилцахад : Дотоодын санхүүжилт бүхий төсөл хэрэгжүүлэн тоног төхөөрөмжийг шинэчилсэн.

Суралцагчдын хөгжмийн зэмсэгжүүлэлтэд анхаарч ЯМАНА төгөлдөр хууртай болгосон нь мэргэжлийн хөгжмийн зэмсгээр хангахад бодит хөрөнгө оруулалт болсон байна.

Уулзалтаар: БУБ-ын 1-4 дүгээр курсын нийт оюутнууд хамрагдсан бөгөөд тэдний 60% нь өөрсдийн хувьдаа худалдаж авсан ардын хөгжмийн зэмсгээр хичээллэж байна.

Дүгнэлт: Багш урлагийн боловсрол суралцагч, багш нарын сурах, сургах материаллаг орчинг бүрдүүлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- 2014 онд мэргэжлийн анги танхимуудын бүх төгөлдөр хуурыг шинэчлэн сольж, ЯМАНА төгөлдөр хууртай болгосон нь суралцагсдад сэтгэл ханамжтай байхаас гадна тэдний хөгжмийн зэмсэг дээр хичээллэх сонирхол, идэвх сайжирсан.
- Багш бүрийг компьютертэй болгосон нь тэдний ажиллах материаллаг орчинг бүрдүүлж чадсан.
- Өөрсдийн дотоод нөөц боломж, судалгаан дээр үндэслэн “Хурган чих” шавар үлээвэр хөгжмийн зэмсгийг үйлдвэрлэж, сургалтад нэвтрүүлж эхэлсэн.

Анхаарах асуудал: Суралцагчдын ардын хөгжмийн зэмсгийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай.

Зөвлөмж: Багш урлагийн боловсролоор бэлтгэж буй боловсон хүчний ардын хөгжмийн зэмсэгжүүлэлтийг нэмэгдүүлэн сайжруулахад бодитой хөрөнгө оруулалт хийж хамтран ажиллах аж ахуйн нэгж, байгууллагад хандах боломжийг судлах

2.1.3. Бие даан болон багаар ажиллах орчны хангалт

Тайлантай танилцахад: Сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцсэн үйл ажиллагаанд оюутнуудын оролцоог нэмэгдүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон, үр бүтээлтэй өнгөрүүлэх, эрүүл чийрэг, зорилготой амьдрахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор 2014 онд “Оюутны хөгжил төв”-ийг байгуулсан.

Оюутны бие даах болон багаар ажиллах орчны хангалт нэмэгдэж, оюутны уран бүтээлч идэвхийг өрнүүлэх зорилгоор жил бүр 2-3 уралдааныг зохион байгуулж байна.

Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв, Цагдаагийн хэлтэс, Чингэлтэй дүүргийн 4, 6 дугаар хороодтой хамтран ажилладаг.

Бодит байдалтай танилцахад: СУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд “Оюутны хөгжил төв”-ийг бүгд ашигладаг. Өдөр бүр нэг сургууль үйл ажиллагаагаа явуулах эрхтэй бөгөөд тогтмол нээлттэй. Сургуулийн 1 давхарт “Оюутны зөвлөл” ажиллах өрөөтэй.

Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хэлтэстэй хамтран “Сайн дурын эргүүл” ажиллагаанд оюутнууд өөрсдийн сонирхлоор оролцож хийсэн ажлын тайлантай.

Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн эмч нартай хамтран “Сайн дурын аян” өрнүүлж, цусаа хандивлах ажлыг зохион байгуулсан байна.

Уулзалтаар: БУБ-ын II курсын оюутан А.Ууганзаяа: СУИС-ийн I-IV курсын 12 оюутан “Оюутны зөвлөл”-ийг бүрдүүлдэг. БУБ-ын 2 оюутан зөвлөлд байх бөгөөд оюутнуудыг идэвхжүүлэх спорт, урлаг, орчноо цэвэр цэмцгэр байлгах олон ажлыг санаачилж, сар тутам ангийн дарга нарын уулзалтыг зохион байгуулж ажилладаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- СӨБ, ЕБС дээр багшлах дадлагын орчинг бүрдүүлэх, сургалтын чанар, үр өгөөжийг сайжруулах зорилгоор тухайн сургууль, цэцэрлэг, соёлын төвүүдтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан⁷ ажиллаж, журмын дагуу ажлын хөлс тооцон олгодог гэж журамлажээ.
- “Оюутны төв” хичээлийн байрнаас тусдаа бөгөөд оюутнууд бие дааж үйл ажиллагаагаа явуулах, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх боломжтой тохилог орчин бүрдүүлсэн.

Анхаарах асуудал:

- СУИС-ийн вэб сайт дахь “Оюутны зөвлөл” цэст 2017 оны 12 сарын 27-ны өдрийн “Оюутан жижүүр” үйл ажиллагаа гэснээс өөр нэмэлт мэдээлэл байршуулаагүй.
- 2017-2018 оны хичээлийн жилд хийх батлагдсан ажлын төлөвлөгөө байхгүй.

Зөвлөмж: Оюутны зөвлөлийн үйл ажиллагааны талаар сургуулийн вэб сайт дахь мэдээллийг шинэчлэх, тэдний үйл ажиллагаанд багш, оюутны хяналтыг сайжруулах, хийсэн ажил, санаачилсан зүйлээ бусадтай хуваалцах тал дээр анхаарах шаардлагатай байна.

Оюутны багшлах сонирхлыг өрнүүлэх, багаар хамтран ажиллах ур чадварыг хөгжүүлэх зорилгоор ЕБС, СӨБ-д урлагийн тоглолт, найрал дуу бэлтгэхэд зөвлөн туслах үйл ажиллагаагаа тогтмолжуулах.

2.2. Сургалтын хэрэглэгдэхүүн, хэрэгсэл

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

2.2.1. Программ хангамж, симуляци, виртуал лабораторийн хэрэглээ, хүртээмж Тайлантай танилцахад: UNICULTURE системийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэдэг бөгөөд сургалтын бүх үйл ажиллагаа тус системээр зохицуулагдсан.

2014 онд 16 нэр төрлийн 29 тоног төхөөрөмж бүхий дуу хөгжмийн бичлэгийн студийг шинээр нээн ажиллуулж сургалт, уран бүтээлийн ажилд ашиглаж байна.

Бодит байдалтай танилцахад: Компьютерийн лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчилж, сургалтад ашиглаж буй 29 суурин компьютер нь хичээлийн хөтөлбөрт зориулагдсан ноотны SONATA, SIBELIUS, FINALE программыг ашиглах, дуу болон

⁷ СУИС-ийн бакалаврын сургалтын журмын 9.10.6

хөгжмийн бүтээлд хөрвүүлэг, найруулга хийх зорилгоор хөгжмийн мэдээллийн технологийн хичээлийг нэвтрүүлсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2013 оноос хойш сургалтад зориулж 6 удаагийн лицензтэй программын, дуу хөгжмийн бичлэгийн студийн 29 ш тоног төхөөрөмжийг шинэчилсэн нь багш урлагийн боловсролын хөтөлбөрийн онцлогт зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулахад хүрэлцээтэй.
- Багш, оюутнууд уран бүтээлийн бичлэг хийх орчин нөхцөл бүрдсэн.
- 1-4 дүгээр дамжааны оюутнууд SIBELIUS ноот бичлэгийн программ дээр бичих, түүнийг хэрэглээ болгох чадварт суралцсан.
- Хөгжмийн онолын Б.Төгсжаргал багш “Хөгжмийн ухаалаг самбар” ашиглаж сургалтыг сонирхолтой, өгөөжтэй болгоход эрэл хайгуул хийж, санаачилгатай ажиллаж байна.

Зөвлөмж: Дуу хөгжмийн бичлэгийн студидэд бичүүлсэн оюутны уран бүтээлийг сурталчилсан мэдээллийг СУИС болон ХУС-ийн вэб сайтад байршуулах

2.2.2. Хичээл практикийн материаллаг нөөц, хэвлэмэл үзүүлэн, тараах материал, хэрэглэгдэхүүний хүртээмж, хэрэглээ

Тайлантай танилцахад: Багшийн файл бүрдүүлэлтийг иж бүрэн хийж, сургалтын хэрэглэгдэхүүн, тараах материалын баяжилтыг тогтмол сайжруулж, сургалтад хэрэглэх аудио, видео материал блог хуудас зэрэг технологийн аргыг нэвтрүүлсэн.

Уралдаан, тэмцээн, уран бүтээлийн тоглолт, явцын болон улирлын шалгалт, төгсөлтийн шалгалтууд, дипломын ажил, нээлттэй хичээл, дадлагын хичээл зэрэгт концертын танхим, тоног төхөөрөмжүүд, анги танхимуудыг хуваарилан, цагийн хуваарийн дагуу хичээлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж сургалт явагддаг.

Бодит байдалтай танилцахад: Багш урлагийн боловсролын чиглэлээр суралцагчдад ерөнхий боловсролын сургуулийн 1-9 дүгээр ангийн сурах бичиг, “Багшийн ном” гарын авлагыг дадлагын хичээлд ашигладаг байна.

Уулзалтаар: Жил бүр элсэн суралцагч оюутнуудад зориулж гарын авлагыг өгч, сургуулийн талаарх мэдээлэл, хөтөлбөрийн онцлог, хичээл сонголт хийхэд хөтөч болгодог.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ХУС-ийн компьютерийн лаборатори, ноот бичлэгийн студи⁸, цахилгаан даралтат хөгжмийн кабинет, оюутан театр⁹ нь тус тусдаа сургалт үйл ажиллагаа явуулах дүрэм, журамтай бөгөөд багш, оюутнууд мөрдөж ажиллах тал дээр хэвшсэн.
- Хөгжмийн онолын Б.Төгсжаргал багшийн “Хөгжмийн онолын хичээлийн гарын авлага” нь суралцагчдын гарын авлага хэрэглээнд бүрэн нийцсэн, ашиглах чадвар нь жигд байна.
- Төгсөгчдийн дипломын бичвэр нь ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт ажиллаж буй хөгжмийн багш нарт гарын авлага болохуйц сэдвийг сонгосон нь цаг үеэ мэдэрсэн бодитой хэрэглэгдэхүүн болсон байна.

Зөвлөмж: Сургуулийн вэб сайт дахь оюутны цэст даалгаврын санг хувилбартайгаар байршуулж, эргэх холбоотой ажиллах боломжийг сайжруулах

⁸ “СУИС-ийн “Дүрэм журмын эмхэтгэл 2015” 299 хуудас

⁹ “СУИС-ийн “Дүрэм журмын эмхэтгэл 2015” 297 хуудас

2.2.3. Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийн хүртээмж

Тайлантай танилцахад: БУБ-ын хөтөлбөрөөр суралцагсад сүүлийн 5 жилд хөгжмийн зэмсэг сонсох хөгжмийн хүртээмж, хэрэглээ сайжирсан. 2015-2016 оны хичээлийн жилд сургалтын ажлыг зохион байгуулах дүрэм журмын эмхэтгэлийг шинэчлэн боловсруулж, заавар удирдамжийг өдөр тутмын сургалтын үйл ажиллагаандаа мөрдөх боломжийг бүрдүүлж, багш бүрт албан хэрэгцээнд нь зориулан олгодог.

Уулзалтаар: Оюутнуудад сургууль, сургалттай холбоотой дүрэм, журмыг танилцуулж, “Оюутны гарын авлага”-ыг хөтөч болгон өгдөг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутнууд гарын авлагыг хэрэглээ болгож чадсан.
- ХУС-ийн компьютерийн лаборатори, ноот бичлэгийн студи¹⁰, цахилгаан даралтат хөгжмийн кабинет, оюутан театр¹¹ нь тус тусдаа сургалтын үйл ажиллагаа явуулах дүрэм, журамтай бөгөөд багш, оюутнууд мөрдөж ажилладаг.

Зөвлөмж: Хичээл практикийн материалын хувьд лекц, дадлагын хичээлийн цаасан иж бүрдлээс гадна хэвлэмэл ба биет үзүүлэн, тараах материал, анонс, слайдуудыг тогтмол ашигладаг нь сайшаалтай байна. Суралцагсдаас авах явцын шалгалтын тест зэрэг хэрэглэгдэхүүнүүдийг онлайн болгон ашиглах.

2.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт мэдээллээр тогтмол, чанартай хангадаг байна.

2.3.1. Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн судалгаа, хүртээмж, хэрэглээ

Тайлантай танилцахад: Ерөнхий, мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээл, хөгжмийн багш заах арга зүйн монгол хэлээр 4971, орос хэлээр 1091, герман хэлээр 425, англи хэлээр 444 сурах бичиг, сэтгүүлүүдтэй.

Сүүлийн 3 жилд хөгжмийн багш нарын хувийн урын санд болон БУБ тэнхим дээр төвлөрүүлэн ажиллаж байна.

СУИС-ийн төв болон III байранд 2017 оны 11-р сарын 22-ны өдөр 70-80 хүний багтаамжтай, 110 м² талбайтай тохилог номын сангууд шинэчлэгдэж, номын сангийн орчинг бүрдүүлсэн. 18247 ш ном сурах бичиг, гарын авлага, 419 ш аудио видео, 1352 ш англи, 77 ш япон, 2269 ш орос, 512 ш сэтгүүлүүдтэй.

Бодит байдалтай танилцахад: Хичээлийн 2 дугаар байрны номын сангаар багш, оюутнууд тогтмол үйлчлүүлдэг. Хичээлийн 3 дугаар байранд захирал асан Д.Бат-Эрдэнийн нэрэмжит номын санг байгуулж, үйл ажиллагаа нь тогтмолжсон тохиолог номын сантай байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш, оюутнууд цахим карт ашиглаж номын сангаар үйлчлүүлж хэвшсэн.
- Суралцагсдын ном унших таатай орчинг бүрдүүлсэн.

¹⁰ “СУИС-ийн “Дүрэм журмын эмхэтгэл 2015” 299 хуудас

¹¹ “СУИС-ийн “Дүрэм журмын эмхэтгэл 2015” 297 хуудас

- Номын сан¹²гийн фондод буй бүх ном хэвлэлийг “Коха” программ ашиглан электрон каталог байгуулан дотоод сүлжээндээ байрлуулсан.

Анхаарах асуудал: Мэргэжлийн сэтгүүлийн хангалт, хэрэглээ бүртгэлгүй байна.

Зөвлөмж: БУБ-ын хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулга арга зүйд нийцсэн гадаад, дотоодын хүлээн зөвшөөрөгдсөн боловсрол судлал, хөгжмийн боловсрол судлалтай холбоотой мэргэжлийн болон эрдэм шинжилгээний сэтгүүл, судалгааны эмхэтгэл зэргийг захиалан хэрэглээнд оруулах.

2.3.2. Виртуал, дижитал видео, аудио болон бусад цахим эх үүсвэрүүдийн байдал

Тайлантай танилцахад: Компьютерийн өргөн хэрэглээнээс гадна мэргэжлийн Sibelius 6, 7, 8.4, Final 5. 7 зэрэг Cubes 8 Audition программуудыг бүрэн ашигладаг. Багш бүр зөөврийн компьютертэй. 2, 3 давхарт хичээл сонголтод зориулагдсан 5 компьютер тогтмол ашигладаг. ХУС-ийн сонголын кабинетийн CD, DVD, ном, сэтгүүл 546 ш, БУБ-ын CD, DVD, ном, сэтгүүлийн тоо 1392 ш ашиглаж байна.

Бодит байдалтай танилцахад: Анги танхим бүрд интернэтийн сүлжээ орсон.

Төгсөгчдийн дипломын бичвэрүүд, ЕБС-ийн сурах бичиг, багшид зориулсан номыг судалж, хөтөлбөр боловсруулах, дадлага ажилд хэрэглэдэг байна. Бар кодны тусламжтайгаар номын сангийн үйлчилгээг зохион байгуулж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Бүх анги танхимууд интернэтэд холбогдсноор дэлхийн хөгжмийн шинэ зохиол бүтээлтэй танилцах, дэлхийд Монголынхоо алдар цууг мандуулж буй төгсөгчдийнхөө уран бүтээл, тоглолтуудаас үзэх, судлах, суралцах үйл ажиллагаандаа ашиглах бүрэн боломжтой.
- Хөгжим сонголын өрөөг акустик сайтай болгож тохижуулсан бөгөөд оюутнууд тогтмол үйлчлүүлж, хэрэглээ болгосон.

Зөвлөмж: Хөгжмийн боловсрол олгох сургалтын арга зүйн талаарх цахим хэрэглэгдэхүүний тоог нэмэгдүүлэх, профессор багш, оюутнуудын хөгжмийн боловсрол олгох цахим сургалтын сан үүсгэж, сургуулийн вэб сайтад зориулагдсан цэстэй болж байршуулах, түүнийг хэрэглээнд оруулах

2.3.3. Цахим орчны хүртээмж, хэрэглээ

Тайлантай танилцахад: Сургалтад зориулагдсан 22 суудалтай компьютерийн лабораторитой. СУИС-ийн номын сан ОХУ-ын үндэсний номын сангаас ахисан түвшний сургалт, судалгааны ажлыг онлайнаар авч ашиглаж байгаа бөгөөд EBSCO мэдээллийн санг сургалтад ашиглах боломжтой. Wi-Fi болон суурин интернэтийг ашиглаж байна.

Бодит байдал дээр: Оюутнууд сургуулийн орчинд интернэтэд орох боломжтой бөгөөд номын сангийн коридорт 5 компьютер байршуулсан бөгөөд оюутнууд ашиглаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Интернэт орчин тогтвортой, хүртээмж, хэрэглээ сайтай, цахим системийн ашиглалт, үйл ажиллагаа тогтмолжсон.

¹² “СУИС-ийн “Дүрэм журмын эмхэтгэл 2015” 252 хуудас

- Сургалтын цагаар Facebook хандалт 18:00 цаг хүртэл хаалттай байдаг нь тэдний хичээлийн цагийг үр дүнтэй зохион байгуулахад эерэг нөлөөтэй.

Зөвлөмж: Багш, оюутнууд Facebook групп үүсгэн сургалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цаг тухайд нь дамжуулж, эргэх холбоо үүсгэж, бие даан суралцах, багаар хамтран суралцах, бие биедээ үнэлгээ өгөх, мэргэжил арга зүйн агуулгаар хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр ашиглах нь зохимжтой.

2.3.4. Сургалт, судалгааны лицензтэй программын ашиглалтын байдал

Тайлантай танилцахад: ХУС-ийн бүх компьютер нь лицензтэй ESET NOD-32 antivirus сургалт судалгаандаа лицензтэй программуудыг хэрэглэдэг. Ноот бичлэгийн лаборатори нь ноот бичлэгийн Sibelius 6. 7. 8 дуу бичлэгийн студи нь Logic pro x=700, Cubes 8, protocols 10, Studio One 3 зэрэг лицензтэй программуудыг сургалт судалгаандаа хэрэглэж байна.

Бодит байдал дээр: БУБ-ын 1-4 дүгээр дамжааны оюутнууд мэргэжлийн программ дээр хичээллэдэг бөгөөд улсын шалгалтын заавал гүйцэтгэх даалгаврын нэг болгож оруулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага: Суралцагсдын эцэг эх, асран хамгаалагчид оюутны вебээр дамжуулан хүүхдийнхээ сурлагын байдал, идэвх оролцоог хянах, сургуулийн сургалтын үйл ажиллагаатай танилцах боломжтой.

Зөвлөмж: Сургалтын программын багшийн вэб дэх судлагдахуун бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг бүрэн байршуулах

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

ШАЛГУУР 3. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

3. 1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

3.1.1. Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдал

Тайлантай танилцахад: СУИС дээр удирдлага мэдээллийн UNICULTURE систем ашиглан сургуулийн болон хөтөлбөрийн бүртгэл мэдээллийг автоматжуулж, сургалтын алба болон багшийн ажил, оюутан багш, удирдлага хоорондын холбоог шийдэх програм хангамж ажиллаж байна. Хөтөлбөрөөр суралцагсдын өдөр тутмын үйл ажиллагаа, төгсөгчдийн үйл ажиллагааг идэвхижүүлэх, ЕБ, СӨБ руу чиглэсэн сургалт, сурталчилгаа зохион байгуулах зэрэг ажлыг тасралтгүй явуулахад удирдлагын үйл ажиллагаа чиглэгдэж байна. Удирдлагын системээр багш оюутны веб, хичээл, хичээл сонголт, тайлан мэдээ, тодорхойлолт, дүнгийн бүртгэл, статистик мэдээ, нэмэлт тайлангууд гэх мэт функцүүд өөр өөрийн зорилгоор хэрэгжиж байна.

Бодит байдал дээр: оюутны болон багшийн веб болох suis.edu.mn/teacherweb болон 198.168.20.2/student веб дээр багш оюутнууд ажиллаж байгаатай танилцлаа. Програмын тандалт, хичээлийн стандартын засвар, дүн оруулах, хэвлэх үйл ажиллагаа зэргийг СУИС-ын сургалтын бодлого зохицуулалтын газар, Сургалт эрхэлсэн дэд захирал нар төв серверээс хяналт хийдэг байна. 2014-2015 хичээлийн жилээс төлбөрийн программыг нэмж суулган ашиглаж байна.

Уулзалтаар: оюутны болон багшийн веб хуудсуудын ашиглалтын талаар дэлгэрэнгүй ярилцаж, удирдлагын мэдээллийн системийн ажиллагаа хэвшмэл байж, багш нар болон суралцагсадын өдөр тутмын хэрэглээ болсон байгааг мэдлээ.

3.1.2. Хөтөлбөрийн нэгжийн /тэнхим, профессорын баг, хөтөлбөрийн хороо/ шийдвэр гаргалт, хэрэгжилтийн үнэлгээнд багш, суралцагчдын оролцоог нээлттэй, ил тод хангасан байдал

Тайлантай танилцахад: Хөтөлбөрийн хариуцсан нэгжийн сургалтын үйл ажиллагаа СУИС-ын тэнхимд тавигдах шаардлага, профессор багш ажиллуулах журмын дагуу явагдаж байна. Тэнхимийн хурал сард 2 удаа, захиргааны зөвлөлийн хурал долоо хоногт нэг удаа хуралдаж, хяналт, үнэлэлт, шийдвэр гаргалтаа СУИС-ийн захиргааны зөвлөлд уламжлан шийдвэрлүүлж ажилладаг. Ил тод байдлыг хангахад msuas.edu.mn, sma.edu.mn багш оюутны веб, цахим бүртгэлийн систем зэрэг веб сайтууд, сургуулийн фейсбүүк, твиттер, блогууд олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй мэдээлэл түгээхэд чухал хэрэглэгдэхүүн болдог байна. Мөн оюутнууд багшийн хичээлд дүгнэлт өгөх асуулга тавигдаж суралцагчдаар хичээлээ үнэлүүлж байна. 2016-2017 оны хичээлийн намрын улирлын бүх хичээлд өгөх асуулгад давхардсан тоогоор 1084 оюутан оролцсон байна. СУИС дээр профессорын 2 баг ажиллаж байгаа нь дорно дахины хөгжим судлалыг С.Соронзонболд, урлагийн боловсрол судлалын багийг Н.Жанцанноров багш нар удирдан ажилладаг байна. Мөн сургалт, судалгааны бүхий л үйл ажиллагаанд оюутан, багш нар ил тод оролцож хувь нэмэр оруулж байна.

Бодит байдал: БУБ хөтөлбөрийн багш нарын хөтөлбөр боловсруулах туршлага, сургууль даяар хэрэгжиж дадал болсон хөтөлбөр нь багш суралцагсдын оролцоог нээлттэй хангасан, багш нар болон суралцагсдад ил тод ойлгомжтой боловсруулагдсан байна. Мөн ЕБС сургууль болон Бадмаараг хөгжмийн дунд сургуулийг төгссөн суралцагсдын чадварыг хөгжүүлэхээс гадна гадаадын оюутнуудын хөгжилд ихээхэн шинэлэг хувь нэмэр оруулахаар боловсруулагдсан байна.

Уулзалтаар: БУБ хөтөлбөрийн төгсөгчид, одоо суралцаж байгаа оюутнуудтай уулзахад оролцогчдын сэтгэл ханамж сайн, хөтөлбөр, нэгжийн шийдвэр гаргалтанд өөрсдийн оролцоог оруулдаг талаар ярьж байлаа.

3.1.3. Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм, журмуудын хэрэгжилт

Тайлантай танилцахад: Багш урлагийн боловсролын хөтөлбөрийг А174 дугаар тушаалаар батлагдсан нийтлэг шаардлагын дагуу боловсруулсан байна. СУИС-ийн 2015 оны дүрэм журмуудыг сургалтын үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг байна. Хөтөлбөрийн үнэлгээ нь хөгжмийн багшийн мэргэжил олгох чадвар чадамж, заах арга зүйд нийцсэн шалгуураар 1-100 оноогоор үнэлдэг. Сүүлийн гурван жилд Бакалаврын сургалтын журмыг 2015 онд шинэчлэн и-сургалтын журам, хос, хавсрага, богино хугацааны сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд баримтлах журам, улирлын болон хагас жилийн шалгалт, шүүлгийн дүнгийн баримт бичгийг архивлах ажлын удирдамж зэргийг 2016-2017 оны хичээлийн жилд шинээр боловсруулан мөрдлөг болгосон байна.

Хөтөлбөрийн чанар, хэрэгжилтийг удаа дараагийн мониторингийн багаас өгсөн зөвлөмжийн дагуу засч сайжруулан мөрдөж байна.

Бодит байдал: СУИС болон Хөгжмийн Урлагийн сургууль даяар хэрэгжиж байгаа дүрэм журмуудтай нягтлан танилцлаа. Оюутны хөгжлийн тал дээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, тэднийг журмаар баталгаажуулсан байгаа нь суралцагсдын эрх, үүрэгт нийцсэн байна.

Уулзалтаар: Улаанбаатар хотын ерөнхий боловсролын хэд хэдэн сургуулийн багш нар уулзалтанд хамрагдсан ба уулзалтаар хөтөлбөрийн шаардлага, мөн суралцагсдын болон төгсөгчдийн чадварын талаар ярилцаж тус хөтөлбөр нь өнөө үеийн боловсролын чиг хандлагад нийцсэн, цаашид элсэгчдийн болон хөгжмийн багшаар суралцах хүсэлтэй иргэдийг олноор бэлтгэн гаргах шаардлагын талаар ярилцлаа.

Онцлог зүйл/Туршлага:

Монгол орны хөгжмийн зэмсгүүд, мөн шинээр шинэчлэн боловсруулж буй “Хурган чих” зэмсгийн үйлдвэрлэлт, зэрэг нь суралцагсад болон залуу хойч ирээдүйн сурагчдын хөгжмийн боловсролд онцгой ач холбогдолтой бүтээл болж байгаа нь сайшаалтай байна.

3.1.4. Урт болон богино хугацааны төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлан, ахиц өөрчлөлтийн дүн шинжилгээ механизм

Тайлантай танилцахад: Багш урлагийн боловсролын хөтөлбөр нь СУИС-ийг хөгжүүлэх 2012-2021 оны мастер төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө, СУИС, Хөгжмийн урлагийн сургуулийн жилийн ажлын график, төлөвлөгөөний дагуу хэрэгждэг байна. Төлөвлөлт гүйцэтгэлийн тайланг жил бүрийн эцэст нээлттэйгээр СУИС-ийн захиргаа, бүрэлдэхүүний сургуулийн захирал, сургалтын алба, багш нарт тайлагнаж, үр дүнг хэлэлцэж цаашдын зорилгоо тодорхойлдог. 2011-2017 онуудад нийт дотоодын болон гадаадын 11 төсөл хэрэгжүүлсэн байгаагаас ахиц дэвшил харагдаж байна. Жишээ нь хөгжмийн багшийн хөтөлбөрийн багш нар нь Монгол улсад үндэсний хэмжээний бүхий л ЕБС-иудад хэрэглэгдэж байгаа 6-7, 8-9 ангийн сурах бичгийг боловсруулан гаргасан байна. Мөн Япон улстай хамтарсан төсөл хэрэгжүүлснээр бага боловсролын багш нарт зориулсан дүрст материал боловсруулсан байна.

3.1.5. Санал, гомдол хүлээн авах, хариу өгөх үйл ажиллагаа, систем бүрдсэн байна.

Тайлантай танилцахад: 2016-2017 оны хичээлийн жилд нийт 44 өргөдөл ирснийг тэнхим хүлээн авч шийдвэрлэсэн байна. Хөтөлбөр солих, шилжилт хөдөлгөөн, сургуулиас гарах гэх мэт өргөдөл хүсэлтийг СУИС-ын дүрэм журмуудын дагуу шийдвэрлэдэг байна. Сургуулийн байранд гомдол, санал хүсэлт, баярлалаа гэсэн 3 хайрцаг байрлуулж оюутны санал гомдлыг хүлээн авдаг. Мөн оюутнуудын өдрийн болон эчнээ хэлбэрээр ангилан санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэдэг байна.

Бодит байдал: Суралцагсад болон багш нарын зүгээс өөрсдийн гаргасан санал, гомдлын хариуг СУИС-ын дүрэм журамд заасны дагуу хэлэлцүүлж хариу аван ажиллаж байна.

Уулзалтаар: шинжээчдэд оюутнуудын хэлж ярьсан гол санал бол тэдний давтах өрөө танхимын асуудал байсан ба оюутны хөгжил төвийн гаргаж буй хуваарь нь дан хөгжмийн хичээл болон ерөнхий төгөлдөр хуурын ганцаарчилсан хичээлийг давтахад хүрэлцээ муутай байдаг байна.

3.1.6. Хөтөлбөрийн багш, ажилтнуудын хүний нөөцийн судалгаа, шинжилгээ, хөгжүүлэх ажлын үнэлгээ, гүйцэтгэлийн болон үр дүнгийн урамшууллын хэрэгжилт

Тайлантай танилцахад: Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш урлагийн боловсролын тэнхим нь 2017 оны 1 сарын 5-ны өдөр байгуулагдсан. Сурган сэтгэл судлалын багш 4, хөгжмийн багш 10, нийт 14 үндсэн багш, цагийн 3 багштай. СУИС-ийн багш сонгон шалгаруулах журмын дагуу олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ажлын байрыг зарлан сонгон шалгаруулж, мөн нөөцөд бүртгэх үйл ажиллагааг явуулдаг байна. Багшийн хөгжил хөтөлбөрийн хүрээнд төсөл хэрхэн бичих, гадаад хэлний шаталсан сургалт, РРТ бэлтгэх сургалт, багшийн хандлага өөрчлөх сургалт, судалгааны арга зүй боловсруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль эрх зүйн сургалтууд, ур чадварын сургалт, мастер класс зэрэг төрөл бүрийн сургалт семинар зохион байгуулж, багш нар идэвхитэй оролцож байна. Багш нарын хөдөлмөрийг бодитойгоор үнэлэхэд анхаарч сургуулийн дүрэм журмын дагуу үр дүнгийн урамшуулал, илүү цагийн хөлс олгох, эрдэм шинжилгээний хуралд тэргүүн байруудад шалгарсан болон эрдэм шинжилгээний ажил бичих, гадаад дотоодод албан ажлаар явахад нь зардал, цалинтай чөлөө урамшуулал олгох зэрэг хөнгөлөлтийг олгон хэрэгжүүлж байна. 2016-2017 оны хичээлийн жилд давхардсан тоогоор 24 багш урамшуулалд хамрагдсанаас 12 сард 14 багш, 3 сард 10 багшид урамшуулал олгосон байна.

Бодит байдал: Тус хөтөлбөрийг зааж байгаа багш нарын чадвар, мэргэжлийн өндөр түвшин нь тэдний уран бүтээл, зохиосон, эмхэтгэсэн сурах бичиг, гарын авлагуудтай танилцахад сайтар ажиглагдаж байлаа.

Уулзалтаар: Цаашид судалгаанд үндэслэгдсэн сурах бичиг гарын авлага хэвлүүлэх, мөн гадаад орнуудын ижил төстэй хөтөлбөрийн үйл ажиллагаа, ирээдүйн чиг хандлагатай сайтар танилцаж хөгжүүлэх талаар шинжээчийн баг, багш нарын хамт олонтой ярилцлаа.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.2 Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

3.2.1. Хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгааны давтамж

Тайлантай танилцахад: СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургууль нь “Үр дүнд суурилсан сургалт, инноваци, уран бүтээлийн төв” болох зорилготой ажиллаж байна. Хөгжмийн багшийн ажлын байрны судалгааг жил бүрийн хавар, аймгуудын боловсрол, соёл урлагийн газрын холбогдох мэргэжилтнүүдээр гаргуулан авдаг. Мөн энэ үйл ажиллагаанд тус хөтөлбөрийн төгсөгчдийн оролцоо их байдаг байна. Эрэлт их аймгуудад багш томилон элсэлт авах, хөтөлбөрөөр сургалт семинар явуулах, орон нутгийн СӨБ, ЕБС-ийн үйл ажиллагаатай танилцах, мэдээлэл авах, өгөх зэрэгт судалгааг байнга ашигладаг. Тайланд дурьдагдсан судалгаанаас үзэхэд манай орны соёл урлагийн байгууллагын ажилтнуудын 47.6 хувь нь тодорхой чиглэлээр мэргэшээгүй буюу, мэргэжлийн бус, (дунд буюу түүнээс доош боловсролтой) байгаа нь салбарын хүний нөөцийн бодлого оновчтой бус нөгөө талаас 7574 хүн ажиллахаас 6813 хүн ажиллаж 761 орон тоо сул байгаа нь орон нутгийн соёл урлагийн байгууллагуудад мэргэжилтэй боловсон хүчин дутагдалтай, орон нутагт ЕБС, СӨБ, Театр чуулга, соёлын төвүүдэд сайн дурын уран сайханчид ажилласаар байгаа нь мэргэжлийн боловсролтой ажилтан, ялангуяа орон нутагт хөгжмийн багш дутагдалтай байгаагийн илрэл юм.

3.2.2. Хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийн арга хэлбэр, хүртээмж, үр нөлөө

Тайлантай танилцахад: хөтөлбөрийг сурталчилах ажиллагаа тасралтгүй хийгдэж байна. Хөтөлбөрт суралцаж байгаа оюутнууд хөдөө орон нутагт, ЕБС, СӨБ-д дадлага хийх хугацаандаа мэргэжлээ байнга сурталчилж байгаагаас гадна сургуулиас жил бүр орон нутагт элсэлт зохион байгуулахад багш нарын оролцоо их байдаг. Мөн сургуулийн веб сайт болон олон нийтийн сүлжээнд сурталчилгааг байнга явуулдаг байна. 2016 оны 11-р сард СХД-ийн 11 сургууль дээр хөтөлбөр сурталчилах үйл ажиллагааг тоглолт хийж зохион байгуулсан байна. Сургалтын албаны даргын баталсан сургууль сурталчилах хуваарийг тайланд тусгасан байна. Хуудас 83. Сурталчилгааны үр дүнд бууралттай байсан элсэгчдийн тоо 2016-2017 оны хичээлийн жилд өссөн үзүүлэлттэй гарсан байна. Мөн мэргэжлийн багш нар нь олон улсын болон улсын чанартай уралдаануудад шүүгчээр ажиллаж, тэргүүн, дэд байранд шалгарсан оролцогчдыг ур чадварын шалгалтгүйгээр оруулдаг нь хөтөлбөрийг сурталчилах нэгэн зохистой арга хэмжээ байна. 2016-2017 оны хичээлийн жилд 3 оюутан урилгаар элсэн орсон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.3 Төгсөлтийн дараах бодлого

Хөтөлбөр нь төгсөгчидтэйгээ байнгын эргэх холбоотой, тэдний мэргэжлийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулж, төгсөгчид нь суралцаж буй суралцагчдад мэргэжлийн чиглэлээр ажиллахад нь зөвлөн тусладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

3.3.1. Төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгаа

Тайлантай танилцахад: 2016 онд тус сургуулийн хийсэн төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаагаар хэн хаана ажиллаж сурч байгааг тодорхой болгож төгсөгчидтэй эргэх холбоогоо улам сайжруулж ажиллаж байна. Мөн нийслэлийн боловсролын газартай хамтран төгсөгчдийн мэргэжил дээшлүүлэх сургалт, семинар, уулзалт зохион байгуулж бүх нийтийн урлагийн боловсролын чиг хандлага нийгмийн сэтгэл зүйн өөрчлөлт, техник технологийн нэвтрэлт, сургалтын арга зүйн шинэчлэлтээр давтан сургалт зохион байгуулах зэрэг ажлууд тасралтгүй хийгдэж байна. Тайланд төгсөгчдийн олон талын чадвар чадамж хэрхэн үнэлэгдэж байгааг талаархи судалгааг хавсаргасан байна.

3.3.2. Үргэлжлүүлэн суралцагчдын хувь хэмжээ

Тайлантай танилцахад: СУИС нь 3.4 голч дүнтэй суралцсан төгсөгчиддөө магистр, докторын сургалтын албанаас шалгалтгүй элсэн суралцах урилга өгөн дэмждэг байна. Энэ нь ахисан түвшний сургалтанд хамрагдах нэгэн хөшүүрэг болдог байна. СУИС-ийн дуу хөгжмийн боловсролын магистрын сургалтын хөтөлбөрийг шинээр боловсруулан сүүлийн гурван жилд шинэчлэгдсэн хөтөлбөрөөр суралцагсдын тоог тайланд хүснэгтээр харуулсан байна.

3.3.3. Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах бодлого, төлөвлөгөө, хамрагдсан байдал

Тайлантай танилцахад: БУБ хөтөлбөрөөр төгсөгчдийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтын үйл ажиллагааг идэвхитэй зохион байгуулж ирсэн нь харагдаж байна. Тайланд үйл ажиллагааг 8 хэсэгт хуваан, хийсэн ажлыг тодорхой харуулжээ. Жишээлбэл: мэргэжил дээшлүүлэх кредиттэй сургалт, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Нийслэлийн боловсролын газар, БСШУСЯ-тай хамтран 1,5,10 дахь жилдээ ажиллаж байгаа багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг БУБ хөтөлбөрийн үндсэн багш нар удирдан явуулдаг байна.

3.3.4. Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны тогтмолжсон байдал N

Тайлантай танилцахад: Төгсөгчдийн холбоо төв сургууль дээр ажилладаг байна. Төгсөгчид зохион байгуулалтад нэгдэн, өөрсдийн фейсбүүк хуудаст холбогдон ажилладаг байна. Цахим орчин нь төгсөгчдийн хувьд багш нар, сургуультайгаа холбоотой байх, тогтмол мэдээлэлтэй байх энгийн бөгөөд чухал хэрэгсэл бож байна. Төгсөгчдийн холбооны тэргүүнээр Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын арга зүйч С.Батболд ажилладаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага: Төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгааг тогтмол хийж байгаа нь одоо суралцаж байгаа оюутан сурагчид, ажил олгогчдын уулзалтуудаас тод харагдаж байна. Тус хөтөлбөрөөр төгссөн төгсөгчид нь ЕБС болон аймаг, орон нутгийн болон гадаад орнуудад мэргэжлээрээ ажиллаж байгаа дэлгэрэнгүй судалгаа байна.

Зөвлөмж: Ажил олгогчид, Улаанбаатар хот болон орон нутгийн сургууль урлагийн байгууллагуудаас хөдөлмөрийн зах зээлийн судалгааг байнга авч байх, Хөгжмийн багшийн сургалтын хөтөлбөрийг орон нутагт байнга сурталчилгаа хийж байх

3.4 Олон улсын харилцаа, хамтын ажиллагаа

Олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

3.4.1. Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн тайлан, дүгнэлт

Тайлантай танилцахад: Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхим нь үүссэн цагаасаа эхлэн гадаадын их, дээд сургуулиудын туршлагыг судлах, хамтын ажиллагаа зохион байгуулахад зохих ач холбогдол өгөн ажиллаж иржээ. 2011-2016 онуудад гадаад харилцааны хувьд хийгдсэн ажлууд нь олон улсын хурал чуулган, эрдэм шинжилгээний хурал, симпозиум, хэлний сургалт, туршлага судлах, мэргэжлийн уралдаан тэмцээнд оролцох зэрэг болно. Хятад, Япон, Герман, ОХУ, Малайз улсуудтай сургалт уран бүтээл, эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр багш оюутан, сургалтын материал солилцох, эрдэм шинжилгээний хурал семинар, сургалт урлагийн тоглолт зэрэг олон хэлбэрээр хамтран ажилласан байна. Багш Ж.Төгсжаргал, Ч.Оюунбилэг нар нь Япон улсад очиж бага боловсролын хөгжмийн хичээлийн туршлага судалсан байна. Мөн тус хөтөлбөрийн багш нар англи хэлний сургалтанд тогтмол хамрагдаж, мөн Герман улсад мэргэжлийн сургалтанд 2 оюутан хамрагджээ. Багш нар олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцон илтгэл хэлэлцүүлж байгааг тайланд баримттай тусган оруулжээ.

3.4.2. Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоо

Тайлантай танилцахад: 2013-2017 онуудад тус хөтөлбөрийн 2 оюутан Тайвань, Японы засгийн газрын тэтгэлэгт хамрагдсан байгаа ба мөн 2 оюутан Герман улсад богино хугацааны сургалтанд хамрагдсан байна. 2013, 2017 онуудад БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хянган аймгийн Ажил мэргэжлийн дээд сургуультай багш оюутан солилцох гэрээ байгуулж, мөн Хянган аймгийн 4 багш манай оронд ирэн зуны сургалтанд хамрагдсан байна.

3.4.3. Олон улсын хурал семинар, судалгаа болон бусад арга хэмжээнд оролцсон тоо, үр дүн, ач холбогдол

Тайлантай танилцахад: сүүлийн жилүүдэд тус хөтөлбөрийн 5 багш Япон, ОХУ, Герман орнуудад очиж олон улсын эрдэм шинжилгээний хурал, богино хугацааны сургалтанд хамрагдсан байна. БУБ хөтөлбөрөөр БНХАУ-аас 1 оюутан суралцаж байна. Гадаадын хэд хэдэн шилдэг их сургуулиудтай хамтран ажиллах зорилго тавин ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага: Олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоож, мөн алсын зайнаас Австрали, Япон, Герман, ОХУ-ын их дээд сургуулиудын ижил төстэй хөтөлбөрийн туршлагаас суралцаж, өөрийн сургуулийн үйл ажиллагаанд нэвтрүүлж байна.

Зөвлөмж: Цаашид үндэсний болон олон улсын хамтарсан төслийн үр дүнг сургалтанд нэвтрүүлэх ажлын хүрээнд инновацид суурилсан судалгааны төсөл үргэлжлүүлэн боловсруулах, гадаад, дотоодын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилтоо хэрэгжүүлэх, хөтөлбөрийг олон улсын түвшинд таниулах цаашид олон улсын хэмжээнд хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх

3.5 Дотоод хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нь мэргэжлийн холбоод, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон ТББ-уудтай хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

3.5.1. Хамтран ажиллах гэрээ, хэлцэл, ажлын үр дүн

Тайлантай танилцахад: Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхим нь багш оюутны дадлагын ажлыг сайжруулах зорилгоор нийслэлийн ЕБС, цэцэрлэгүүдтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажилладаг байна. Оюутан суралцах хугацаандаа 4 удаа дадлагад гарах ба эдгээр дадлагуудыг хамтран зохион байгуулах, удирдлагаар хангах ажиллагааг гэрээгээр зохицуулан ажилладаг байна. Мөн аймгуудтай хамтран ажиллах зорилгоор Баянхонгор, Завхан, Дундговь аймгуудын хөгжмийн багш нарт эчнээ хэлбэрээр сургалт явуулж байна. Энэ сургалтанд дээрхи аймгуудаас нийт 61 багш хамрагджээ. МУБИС-ийн Багшийн сургуультай хамтран “Хөгжмийн боловсролын чиг хандлага” онол практикийн бага хурал, дуу хөгжмийн багш бэлтгэхэд баримталж байгаа бодлого, чиг хандлага, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ сэдвээр БСШУСЯ-нд танилцуулга хийж хэлэлцүүлэг явуулсан байна.

3.5.2. Хэрэгжүүлж буй ажлуудын тайлан, дүгнэлт

Тайлантай танилцахад: Тус тэнхим нь БСШУСЯ-аар батлуулсан хөтөлбөрөөр кредиттэй төрөлжсөн сургалтыг жилд 2 удаа, орон нутгийн соёлын төвийн хөгжмийн багш нарын хөгжмийн багш нарын 21 хоногийн сургалт, нийслэлийн хөгжмийн багш нарт зориулагдсан үндсэн сургалт, аймгуудын БСГ-ын хүсэлтээр мэргэжил дээшлүүлэх сургалт зэргийг байнга зохион байгуулж хамтран ажиллаж байна.

3.5.3. Хамтын ажиллагааны арга, туршлага

Тайлантай танилцахад: Тус хөтөлбөрийн хүрээнд гэрээт болон төсөлт ажлуудыг хийж гүйцэтгэх мэргэжлийн туршлагатай баг ажилладаг байна. Тус багийн хийсэн ажил нь хүүхдийн хөгжмийн боловсрол, хөгжмийн боловсролын стандартыг тодорхойлж сургалтын суурь бичиг баримтууд, сургалтын үндсэн хэрэглэгдэхүүн болдог байна. 2016 оноос хойш, ЕБС-ийн хөгжмийн хөтөлбөрийг 12 жилд тохируулан боловсруулах ажилд Ч.Оюунбилэг, С.Баасандулам, Ж.Ууганцэцэг, Х.Ариунаа, Д.Ариунаа багш нар ажиллаж байна.

3.5.4. Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо үр дүн /багш, суралцагчдын зүгээс

Тайлантай танилцахад: Тус хөтөлбөрийн хэрэгжүүлэгч нарын нийгэмд үзүүлсэн үйлчилгээ, хамрагдсан оролцогчдын тоог хэвлэл мэдээллийн хэрэгслээр зохион байгуулсан ажлууд, байгууллага, ард иргэдэд мэргэжил арга зүйн зөвөлгөө өгсөн байдал, ЕБС-ын сурагчдын авьясыг нээн илрүүлэх дэмжих ажиллагаа зэргийг дэлгэрнгүй байдлаар хүснэгтээр үзүүлжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага: Хамтрагч байгууллагуудыг түшиглэн багш нарын болон оюутны судалгааны ажил тогтмол хийж байна. Судалгааны ажлын гол чиглэлд ЕБС-ын дуу хөгжмийн ангийн танхим, кабинетын тохижилт, Монголын болон гадаад орнуудын уран бүтээлийн тоглолтууд, боловсролын шинэчлэлд зориулагдсан ном, сурах бичгүүд багтаж байна.

Анхаарах асуудал: Монгол улсын ЕБС-дад мэргэжлийн хөгжмийн багшийн дутагдал байгааг анхааран элсэгчдийн тоо, хамтран ажиллах байгууллагын тоог нэмэгдүүлэх

3.6 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

3.6.1. Төсөв, санхүүгийн бие даасан байдлын хөгжил

Тайлантай танилцахад: СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургууль нь бие даасан санхүүгийн эх үүсвэртэй. Сургалтын төлбөр, төслүүдийн орлого, богино хугацааны сургалтын орлого болон бусад орлогууд байдаг байна. Тайланд гадаад орнуудын урлагийн их дээд сургуулиуд, тухайлбал Австралийн засгийн газар урлагийн их сургуулийн 200 кредит тутамд 9033 австрали доллар зарцуулдагийг дурьдаад, манай орны хувьд урлагийн боловсролд төрөөс санхүүгийн дэмжлэг хэрэгтэй байдаг талаар дурьджээ. Сургалтын төлбөрийн орлого болон бусад эх үүсвэрийг 2012-2016 оноор нийт орлогод эзлэх хувийг тайланд графикаар харуулсан байна. Нийт орлогын 4.9 хувь нь төсөл хөтөлбөр, 95.1 хувь нь үндсэн сургалт болон нөхөн судлах хичээлийн сургалтын төлбөрөөс бүрдэж байна. Эдгээр орлогыг багш нарын үндсэн цалин хөлс, багш суралцагчдын хөгжилд зарцуулж байгаа ба 2014, 2015, 2016 онуудаар нийт зарлагын дүнг хүснэгтээр харуулжээ.

3.6.2. Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо

Тайлантай танилцахад: Сүүлийн гурван жилээр орсон нийт сургалтын төлбөр болон сургалтын төлбөрийн авлагын нийлбэрийг тухайн жилд суралцсан оюутны тоонд харьцуулан гарсан сургалтын төлбөрийн дунжийг хүснэгтээр харуулжээ. Урлагийн сургуулийн онцлогоос шалтгаалан оюутны суралцах хичээлийг 3 бүлэгт хуваадаг бөгөөд үнэлгээ нь ялгаатай байдаг байна. Үүнээс шалтгаалан оюутан тус бүр хичээл сонголтоор өөр өөр төлбөр төлдөг байна. Сургуулийн хичээлийн жилд мөрдөх багц цагийн үнэлгээг 5 жилээр харьцуулан тавьсан байгаа ба үүнээс харахад 2016-2017 оны хичээлийн жилд багц цагийн суурь үнэлгээ өсөөгүй үзүүлэлттэй байна.

3.6.3. Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв

Тайлантай танилцахад: Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгчид нь бага сургуулийн хүүхэд нэг бүрийг монгол урлаачийн үйлдвэрлэсэн үлээвэр хөгжмөөр хөгжимдүүлж сургах зорилгоор “хурган чих эртний хөгжмийг ЕБС-ийн сургалтанд нэвтрүүлэх нь” төслийг хэрэгжүүлж эхний шатандаа явж байна. Уг төсөл нь 100.624.599 төгрөгийн санхүүжилттэй байна.

3.6.4. Төр хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалт

Тайлантай танилцахад: БУБ хэрэгжүүлэгч Хөгжмийн урлагийн сургууль нь гадаад дотоодын төсөл хөтөлбөрүүд, яам тамгын газрын хөрөнгө оруулалт, хандив тусламжаар сургалтын баазыг өргөжүүлэн ажиллаж байна. 2013 онд 148.591.780 төгрөгөөр хөгжмийн зэмсэг, 4.097.500 төгрөгөөр ноотны пульт, сандал, удирдаачийн пульт худалдан авч мэргэжлийн хичээлийн баазыг өргөжүүлсэн байна. 2015 онд БСШУЯ-ны санхүүжилт

болох 16 сая төгрөгөөр “Монгол хаадын ордны 7,9,11 чавхдаст ятгыг сэргээх төсөл”-өөр эртний ятгыг сэргээн бүтээж сургалтанд хэрэглэж байна. Мөн БСШУЯ-наас 70 ширхэг 4.200.000 төгрөгийн найрал хөгжмийн сандал хандивласныг сургалтанд ашиглаж байна. 2015-2016 оны хичээлийн жилд СУИС-ийн сургууль хөгжүүлэх сангийн санхүүжилттэй 34.600.000 төгрөгийн “Сургалт, уран бүтээлийн урын сангийн шинэчлэл” төсөл хэрэгжүүлж 23 бүтээлээр сургалтын урын санг баяжуулсан байна. Мөн Хаан банкны хандиваар 2.783.500 төгрөгийн үнэ бүхий 2 шинэ, 5 хуучин компьютер өгснийг үндсэн хөрөнгөд бүртгэн ашиглаж байна.

3.6.5. Төсвийн уламжлалт бус эх үүсвэр, бүрдүүлэлт, хуваарилалт, санхүүжилт
Тайлантай танилцахад: Төсвийн уламжлалт бус эх үүсвэрийг богино хугацааны сургалтыг аймгуудад зохион байгуулах, мөн оюутнуудын ур чадвар дадлыг хөгжүүлэх зорилгоор гадны байгууллагуудын санхүүжилтээр хэрэгжүүлэх боломжтойг дурьдсан байна. Эдгээр орлогыг сургагч багш нарын цалин хөлснөөс гадна албан хэрэгцээний зардал, сургагч багш нарын мэргэжил дээшлүүлэлт, гадаад орноос туршлага судлахад зарцуулдаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага: Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нь төсөв санхүүгийн хувьд СУИС-ийн нэгдсэн төсөвөөс санхүүждэг байна.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

ШАЛГУУР 4. СУРАЛЦАГЧИД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

4.1 Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

4.1.1. Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалтад хөтөлбөрийн онцлогт нийцсэн шалгуурыг тусгасан байдал

Тайлантай танилцахад: Мэргэжлийн чиглэлээс хамаарч 400-450 хэмжээст оноо байхаар тогтоож мөрддөг. Ур чадварын шалгалт 800 оноо Ерөнхий, онцлог гэсэн 2 чадвараар шалгадаг.

Ерөнхий чадварт:

- а. Хөгжимдөх чадвар (төгөлдөр хуураар 2 зохиол)
- б. Хэмнэл
- в. Сонсгол ой тогтоолт

Онцлог чадварт:

- а. Сонгосон хөгжмийн зэмсгээр 2 зохиол хөгжимдөх
- б. Урлагийн тухай ярилцлага
- в. Биеийн хөгжил
- г. Дуулах чадвар

Бодит байдал дээр: Өдөр, эчнээ сургалтын элсэлтийн үйл ажиллагааг¹³ зохион байгуулдаг. Хөтөлбөрийн онцлогт тохирсон ур чадварын шалгалтыг ерөнхий, онцлог чадвараар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Уулзалтаар: Хувь хүнээс мэдрэмж, урлагийн авьяас зайлшгүй шаарддаг мэргэжил учраас онцлог шалгалт байх нь зүйтэй гэж оюутнууд үздэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- СУИС-ийн харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллежид суралцсан чиглэлийн дагуу гүнзгийрүүлэн элсэхийг хүсэгч ЭЕШ өгч бүртгэлийн босго онооны болзлыг хангасан тохиолдолд ур чадварын шалгалт авахгүйгээр хяналтын тоонд багтаан хөтөлбөрт элсэх боломжтой.
- СУИС-ийн харьяа Бадмаараг ахлах төрөлжсөн сургуулийн сурагчдаас ХУС-д элсэн суралцах бүрэн боломжтой.

Анхаарах асуудал: Хүсэлт гаргасан элсэгчдийн тоо, нийт суралцагсдын харьцуулсан тоон судалгааг илүү тодорхой гаргах

4.1.2. Элсэгчдийн ЕШ-ийн дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа

Тайлантай танилцахад: Босго оноо 2013 - 2017 онд 400 оноотой байна. БУБ-ын чиглэлээр 2013-2014 онд 55, 2014-2015 онд 63, 2015-2015 онд -26 элсэгч. Тус хөтөлбөрөөр элсүүлэхэд зөвхөн авьяас, ур чадвар, ЭЕШ-ын онооноос гадна ёс зүйн хэм хэмжээг чандлан мөрддөг, багшлах хүсэл сонирхолтой, мэргэжилдээ дуртай, бие бялдрын зөв төлөвшилтэй элсэгч сонгон шалгаруулснаар хөтөлбөр амжилттай хэрэгжих үндэс, суурь болно.

Уулзалтаар: БУБ-д элссэн суралцагсад өөрсдийн сонгосон мэргэжилдээ дуртай, цаашид энэ чиглэлээр ажиллах сонирхолтой байгаа нь ярилцлагаас харагдаж байсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал: 2012-2013 оны хичээлийн жилээс элсэгчдийн тоо буурсаар байна.

Дүгнэлт: Бакалаврын оюутанд зориулсан гарын авлагыг жил бүр тухайн жилийн элсэгчдэд зориулан гаргадаг нь сайшаалтай.

4.1.3. Шинээр элссэн суралцагчдыг чиглүүлэх сургалтад хамруулж, мэдээлэл, гарын авлагаар хангадаг

Тайлантай танилцахад: Жил бүрийн 8-р сарын 22-ноос 9-р сарын 1 хүртэл сургуулийн захиргаа уулздаг. Шинээр элсэгчдэд хичээлийн жилийн эхэнд зөвлөн чиглүүлэх зорилгоор сургалтын албанаас танилцуулах уулзалт, хурал зохион байгуулдаг.

ХУС"-ийн "Оюутны дэвтэр", "Оюутны гарын авлага"-ыг үнэ төлбөргүй өгдөг. Тэдэнд чиглүүлэг өгч тогтмолжсон.

Уулзалтаар: "Оюутны гарын авлага"-ыг жил бүр шинээр элссэн суралцагсдад өгч, сургалтын албанаас багш нарыг хуваарилан чиглүүлэг өгөх ажлыг зохион байгуулдаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

¹³ СУИС-ийн захирлын 2015 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн А/149 дүгээр тушаал Бакалаврын сургалтын журмын 3-р бүлэг

- (<http://202.613.162.306.188/student/>)-ыг ашиглан хичээл сонголтыг хийх мэдээлэл авч болдог.
- Шинэ элсэгчдийг хичээлийн жилийн хуанлийг заавал хийж, гүйцэтгэх чадварт суралцуулдаг.
- Улсын хэмжээнд хөгжмийн багш дутагдалтай байгаа ч 4-5 жилийн дараа хөгжмийн багш нарын эрэлт хэрэгцээ хангагдах боломжтой.
- Оюутан гарын авлагад оруулсан материалыг нарийвчлан судалсны үндсэн дээр өөрийн эзэмших мэргэжилдээ бүтээлчээр суралцахын тулд хэрхэн суралцах, ажиллахаа төлөвлөж мэдэж болно.

Анхаарах асуудал:

- 2012-2013 оны хичээлийн жилээс элсэгчдийн тоо буурсаар байна.
- Их дээд сургуулиудын консерциумын элсэлтийн шалгалтын комиссын бүрэлдэхүүнд хөгжмийн мэргэжлийн хүн ажилладаггүйгээс мэргэжлийн хуваарь хоосон буцдаг, эсвэл мэргэжлийн шаардлага хангахгүй элсэгчид ордог гэдгийг бодлогоор зохицуулах шаардлагатай байна.

Зөвлөмж: ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад “Багш урлагийн боловсрол”-ыг сурталчлах, энэ мэргэжлээр бахархах, мэргэжил сонгоход арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулбал энэ мэргэжлээр элсэх элсэгчдийн тоог нэмэгдүүлэх боломжийг судлах

4.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчдад суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

4.2.1. Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, график, үр дүн

Тайлантай танилцахад: Хичээлийн жилийн туршид хийгдэх ажлын график гарган батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажилладаг.

БУБ хөтөлбөрийн зорилго: Хүнлэг энэрэнгүй, ёс суртахууны хувьд төлөвшсөн, багш боловсролын онол, арга зүйг эзэмшсэн, багшлах эрхтэй, хөгжмийн боловсролын олон талт үйл ажиллагаа удирдан зохион байгуулах ур чадвартай болсон байна.

Уулзалтаар: Оюутнуудаас хичээлийн жилийн эхэнд зөвлөн туслах ажлын саналыг авч тухайн хичээлийн жилийн төлөвлөгөөнд тусгадаг байна.

Зөвхөн багшлах ур чадвараас гадна олон талын зохион байгуулах авьяасаа хөгжүүлэх тал дээр эрэл хайгуул хийж ажилладаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Эцэг эх асран хамгаалагчидтай холбоотой ажиллах, сургууль-оюутан-эцэг эхийн гурвалсан гэрээ хийж харилцаатай ажилладаг.
- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээг 5 чиглэлээр төлөвлөж, үр дүнг тооцдог.

Анхаарах асуудал

Зөвлөмж: Оюутанд үзүүлж буй зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээ, түүний үр дүнг тооцон тоон үзүүлэлтээр илүү тодорхой гаргаж мэдээлдэг байх.

4.2.2. Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны багш, эмч, сэтгэл зүйч нарын үйлчилгээний чанарын үнэлгээ, сайжруулалт

Тайлантай танилцахад: Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны эмч, сэтгэл зүйч нарын ажлын чиг үүргийг бичсэн. 1, 2 дугаар курсын 49 оюутнуудаас авсан судалгаатай.

Уулзалтаар: БУБ хөтөлбөрт зөвлөх багш 1 буюу Ч.Оюунбилэг. Сургалтын менежер бус мэргэжилтэн нэршилтэйгээр тус тус ажилладаг. Зөвхөн тэнхим дээр 1 туслах ажилтантай.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- БУБ хөтөлбөрийн 1, 2 дугаар курсын 49 оюутнуудаас “Бие хүний зан төлөвийн өөрийнхөө хэв шинжийг тодорхойлох DISG загварын судалгааг авч, нэгтгэл хийсэн.
- Эмч, сэтгэл зүйч нь оюутны дотуур байранд ажиллаж, шаардлагатай үед бүх оюутнуудад үйлчилгээ үзүүлж байна.
- СУИС-ийн дотуур байрны багшийн ажлын чиг үүргийг тусгасан.

Зөвлөмж: Зөвлөх багш, тэнхимийн туслах ажилтан, сургалтын мэргэжилтэн, байрны эмч, сэтгэл зүйч нарын үйлчилгээний чанарын үнэлгээ, сайжруулалтыг оюутны сэтгэл ханамжийн судалгаагаар гаргаж тогтмолжуулах.

4.2.3. Бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн /зан үйл, зөрчил шийдвэрлэх, эрүүл аж төрөх г.м/ чиглэлүүдээр сургалт явуулж, ур чадвар олгодог байдал

Тайлантай танилцахад: Бие хүний төлөвшлийн чиглэлээр нээлттэй ярилцлага 1, уралдаан 4, Харилцаа, ёс зүйн чиглэлээр лекц концерт-1, Зан үйл, зөрчил шийдвэрлэх чиглэлээр өдөрлөг-1, сургалт лекц-1, дадлага сургуулилт-1, Эрүүл аж төрөх чиглэлээр сайн үйлсийн аян-1, спорт наадам-1 тус тус зохион байгуулсан байна. /122/

“Өгөх өдөр” хүмүүнлэгийн сайн үйлсийн аяны хүрээнд багш, албан хаагч, оюутан 97 хүн 35 л цус хандивлаж, 105 хүний амийг аварсан. Спортын 4 төрөлтийн тэмцээнийг “Оюутны зөвлөл”-тэй хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг.

Уулзалтаар: Оюутны дотуур байранд амьдардаг оюутнуудад Чингэлтэй дүүргийн 4, 6 дугаар хороодын эмч нар ирж үзлэг хийхээс гадна эрүүл аж төрөх чиглэлийн сургалтыг 2 удаа өгсөн. Оюутнуудыг вакцинд бүрэн хамруулсан. Байрны зөвлөлөөс жил бүр спортын тэмцээнийг уламжлал болгон зохион байгуулдаг. Мөн “Өгөх өдөр”-т оюутнууд ач холбогдолтой хандаж цусаа өгдөг байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэшүүлэх хичээлийн багш нар суралцагсдыг анхаарч, найз нөхдийг нь судалж, холбоотой байж сэтгэл зүйд нь эерэгээр нөлөөлөх сургалтыг явуулдаг.
- Төгсөгчдөөс эргэх холбоотой ажиллахаас гадна гадаад дотоодын доктор, профессоруудын лекц, нээлттэй ярилцлага, онол практикийн хурал, хүмүүнлэгийн сайн үйлсийн аяныг хамтран зохион байгуулж хэвшсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.2.4. Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлыг үнэлдэг байдал

Тайлантай танилцахад: ХУС-ийн БУБ-ын тэнхимийн 3-р курс болон төгсөх ангийн оюутнууд цэцэрлэг, ЕБС-ийн урлаг, соёлын ажлыг зохион байгуулахад тусалдаг. Оюутнууд дадлагын хугацаанд СӨБ, ЕБС-ийн хичээлээс гадуурх үйл ажиллагааг бие даан зохион байгуулах анхан шатны дадлыг эзэмшдэг.

Уулзалтаар: Дадлага хийсэн сургууль, цэцэрлэгийн багш нартай байнгын эргэх холбоотой ажиллаж, тусалдаг. Мөн тэднээс туршлага судалж суралцдаг.

Онцлог зүйл/Туршлага:

- ЕБС, СӨБ-ын уламжлалт уралдаан тэмцээний бэлтгэл хийхэд хамтран тусалж, дадлага удирдагч багш үнэлдэг.
- СУИС-ийн оюутны эрдэм шинжилгээний хурлыг жил бүр зохион байгуулснаар оюутны илтгэх, бичих ур чадварыг хөгжүүлэх, бие дааж судалгаа хийх, тэдний

шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх, судалгааны чиг баримжаатай болгон хөгжүүлж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт: Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлыг үнэлдэг боловч дүгнэсэн тоон судалгаатай болж, үйл ажиллагааг тогтмолжуулах

4.2.5. Суралцагч, төгсөгчдөд хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлдэг байдал

Нэмэлтээр: Тайланд тусгагдаагүй тул нэмэлтээр мэдээллийг авав. Ажил олгогч байгууллагаас Хөгжмийн урлагийн сургууль болон Багш, урлагийн боловсролын тэнхимд хүсэлт гаргасны дагуу төгсөгчдийг бэлтгэн ажлын байраар хангадаг. Мөн суралцах хугацаанд СӨБ болон ЕБС дээр дадлага хийх үед тухайн байгууллага төгсөх үед нь ажлын санал болгодог. Жишээ нь: Ажил олгогч байгууллагаас хүсэлт тавьсны дагуу төгсөгчдийг ажлын байранд зуучилсан судалгаатай.

Уулзалтаар: Сүүлийн жилүүдэд нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн захирлууд өөрсдийн биеэр ирж ажлын байрны санал гаргаж, төгсөгчдийг ажлын байртай болгоод байна.

№	Хичээлийн жил	Хүсэлт гаргасан байгууллага	Шийдвэрлэсэн байдал
1.	2011-2012	Сакура сургууль	Д.Түвшинжаргал
2.	2013-2014	Монгени ахлах сургууль	Б.Номинзул
3.	2015-2016	84-р сургууль	Х.Нансалмаа
4.	2015-2016	84-р сургууль	У.Ууганцэцэг
5.	2016-2017	84-р сургууль	Э.Янжинлхам
6.	2016-2017	Монгени сургууль	Б.Наранбаяр

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Улаанбаатар төдийгүй хөдөө орон нутагт багш урлагийн боловсролын ажлын байрны эрэлт хэрэгцээ их байна.
- Ажил олгогч байгууллагаас хүсэлт гаргасны дагуу төгсөгчдийг ажлын байранд зуучилсан судалгаатай болсон байна.

Зөвлөмж: Ажлын байрны эрэлт хэрэгцээ ихтэй байдаг ч төгсөгчдөөр дамжуулан хөдөлмөрийн биржийн үйл ажиллагааг хамтран явуулах боломжтой.

4.2.6. Суралцагчийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг дэмжин тусласан байдал

Тайлантай танилцахад: Суралцагчийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг дэмжин туслахад “СУИС-ийн бакалаврын сургалтын журам”-ын 10.1.3 баримтлан ажилладаг. Ихэвчлэн төгсөх ангийн оюутны дипломын сэдэв, түүний судалгааны үе шатны танилцуулга хийх байдлаар бакалаврын оюутны дунд эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж хэвшээд байна.

Бодит байдал дээр: ХУС-ийн оюутнуудын бакалаврын 2 дипломын бичвэрүүдээс сонгож танилцсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Бакалаврын төгсөх ангийн оюутнуудын дунд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд амжилттай оролцож, үнэлгээний голч дүн 2,5 ба түүнээс дээш бол төгсөлтийн ажил бичих эрх олгодог.

- Бакалаврын төгсөлтийн бичвэр нь хөгжмийн багш нарын эрэлт хэрэгцээнд нийцэхүйц, хүүхдийг хөгжүүлэхэд түлхэц болох сэдэв сонгосон нь ололттой.

Анхаарах асуудал:

Нэр төрөл	2015	2016	2017	2018 он	Нийт зардалд эзлэх хувь			
				төсөв	2015	2016	2017	2018
Эрдэм/ш зардал	6.263.95	7.175.33	29.425.8	32,300	0.30%	0.36%	1.32%	1.28%

- Эрдэм шинжилгээний зардалд зарцуулах мөнгөн дүн хэдийгээр өссөн үзүүлэлттэй харагдаж байгаа ч нийт зардалд эзлэх хувь багасч байна.

Зөвлөмж: Дадлагын хугацаанд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг дээр ажиллахад оюутнуудад тулгарч буй бэрхшээл, нэн тэргүүнд шаардлагатай зүйл, түүнийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхэд нь оюутнуудад зориулсан гарын авлага, хэрэглэгдэхүүнийг бэлтгэх зорилгоор бакалаврын бичвэрийн сэдвийн цар хүрээг өргөтгөх.

4.3. Оюутны байгууллагад үзүүлэх дэмжлэг

Оюутны байгууллагаас санаачилсан нийгэмд үзүүлэх үйлчилгээг дэмжин хамтран ажилладаг байна.

4.3.1. Оюутны сайн дурын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, дэмжсэн байдал

Тайлантай танилцахад: 2014 онд “Оюутны хөгжил төв”-ийг 4 орон тоотойгоор байгуулсан. “Оюутны хөгжил төв”-ийг 62,4м² талбайтай байр барьж үйл ажиллагаа нь тогтмолжсон. Нийгэмд хандсан 5 үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон.

2013 оноос “Соёлын наадам”, “Гудамжны баяр” арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулж байна. СУИС-ийн Бадмаараг ахлах сургуулийн сурагчид “Илгээлтийн эзэд” малчдад тусламж цуглуулах тоглолтыг дэмжин 2,6 сая төгрөгийн үнэ бүхий бараа цуглуулж хандивласан. Оюутнуудын нийгмийн идэвх оролцоог сайжруулах зорилгоор “Хөөсний баяр”, ХСИС-ийн оюутны холбоотой хамтран “Нөхөрсөг холбоо” арга хэмжээг тус тус зохион байгуулсан.

Уулзалтаар: “Оюутны хөгжил” төвөөс тусдаа БУБ-ын оюутнуудын дунд “Өвөрхангайн оюутнууд”-ын бүлгэм ажиллаж оюутнууд өөрсдөө ажил санаачилж зохион байгуулдаг болсон.

Онцлог зүйл/Туршлага:

- Нийгэмд хандсан үйл ажиллагаанд хамрагдсан хүний тоо, хүрсэн үр дүнгийн судалгаатай.
- “Оюутны хөгжил төв”-ийн дэргэд “Мэдээллийн төв” ажиллуулж, ирсэн зочдод шаардлагатай мэдээллийг хүргэх, хэвлэх, хувилах үйлчилгээг үзүүлдэг.
- Мэргэжлийн хичээлийн агуулгын хүрээнд олж авсан мэдлэгээ дадлага болгон хэрэгжүүлж хамтын уран бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж байна.
- “Соёлч оюутан” аяны хүрээнд Оюутны зөвлөл уриалга бүхий зурагт хуудас хэвлүүлэн ариун цэврийн өрөөнд байршуулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж: СУИС-ийн цахим хуудаст Оюутны сайн дурын үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллагын мэдээллийг шинэчлэн байршуулах

4.3.2. Оюутны байгууллагын үйл ажиллагааг явуулах төсөв, клубын үйл ажиллагааг дэмжих санхүүжилттэй байх, зориулалтын дагуу зарцуулдаг байдал

Тайлантай танилцахад: ХУС-ийн сургуулийн оюутны санаачилгаар:

- Гитар сонирхогчдын клуб
- Бүтээлч оюутны клуб
- Шатар сонирхогчдын клуб
- Сайн дурын ажилтны клуб хичээллүүлдэг.

2013 оноос 2016 он хүртэл зарцуулсан хөрөнгийн хэмжээ нь нэмэгдсэн.

Онцлог зүйл/Туршлага:

- “Оюутны хөгжил төв”-д өдөр өдрөөр ээлжилж үйл ажиллагаагаа явуулах боломжтой.
- БУБ-ын хөтөлбөрийн суралцагсад бусад сургуулийн оюутны авьяас чадварыг хөгжүүлэх давуу талтай.
- 2013 онд 313,000₮ “Оюутны зөвлөл”-ийн гишүүдэд шагнал, урамшуулал олгосон байна.

Анхаарах асуудал: Санхүүгийн мэдээлэл дээр СУИС-ийн ХУС гэсэн зарцуулалттай ч БУБ хөтөлбөрийн зарцуулалтыг тусад нь харах боломжгүй.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж: БУБ хөтөлбөрийн тухайд санхүүжилтийн өөр эх үүсвэртэй болох оролдлого харагдаж байна. Оюутны байгууллагад үзүүлэх дэмжлэгийн санхүүжилтийг нэмэгдүүлэх шаардлагатай.

4.3.3. Оюутны байгууллагын зүгээс санхүүгийн зарцуулалтаа ил тод тайлагнадаг байдал

Тайлантай танилцахад: Тайлагнасан зүйл байсангүй.

Уулзалтаар: Санхүүгийн ажилтнуудтай уулзаж тодруулахад СУИС гэсэн том хүрээгээр л зарцуулалтыг харах боломжтой. ХУС гэж тусдаа санхүүжилт нь байхгүй байна.

Анхаарах асуудал: СУИС-ийн вэб сайтын шилэн дансан дахь мэдээлэл хангалтгүй.

Зөвлөмж: Оюутны байгууллагын зүгээс санхүүгийн зарцуулалтын тал дээр анхаарч, шилэн дансны ил тод байдал, зарцуулалт, хяналтыг дээшлүүлэх шаардлагатай байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

4.4. Суралцагчийн урамшууллын тогтолцоо

Суралцагчдын амжилтыг хөхүүлэн дэмжих урамшууллын системтэй байна.

4.4.1. Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо

Тайлантай танилцахад: Олон улсын тэтгэлэгт хөтөлбөрт 2-4-р курсын 3 оюутан хамрагдаж байна. Тайваны тэтгэлэгт хөтөлбөрт-2, Японы засгийн газрын хөтөлбөр-4, Герман улсын төсөл хөтөлбөрт-3 оюутан хамрагдсан.

Уулзалтаар: “Бүтээлч оюутан багш”, “Хөгжимдөх ур чадварын уралдаан”-д амжилт үзүүлсэн оюутнуудад дэмжлэг үзүүлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага: Улирал дараалан амжилттай суралцсан оюутнуудад сар болгон тэтгэлэг олгодог.

Дүгнэлт: Нэр бүхий, сургалтын төрийн сангаас бусад олон улсын, Засгийн газрын тэтгэлэг болон хөтөлбөрт хамрагдсан оюутны тоо харьцангуй цөөн байна.

Зөвлөмж: Боловсролын зээлийн сангийн сургалтын төлбөрийн буцалтгүй тусламжид заагдсан “Багш бэлтгэдэг төрийн өмчийн их, дээд сургуульд багш мэргэжлээр элсэгч нь ЭЕШ-д 650-750 оноо авсан бол сургалтын төлбөрийг 70%, 751-ээс дээш оноо авсан бол сургалтын төлбөрийг 100% чөлөөлнө” гэсэн заалт нь БУБ-д хамрагдаж буй оюутанд хамаарахгүй байгааг нэгжээс санал боловсруулж тусгаж оруулах боломжийг судлах.

4.4.2. Суралцагчдын үзүүлсэн амжилтууд

Тайлантай танилцахад: Universe best songs -3, Хөхөө Намжил шоу-1 оюутан тус тус үзүүлсэн амжилтуудтай.

Онцлог зүйл/Туршлага: Мэргэжлийн онцлогоос шалтгаалж, олон уралдаан тэмцээнд оролцох боломж оюутан бүрт байдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт: ХУС-ийн оюутнуудын үзүүлсэн амжилт сайн. БУБ хөтөлбөрийн суралцагчдаас үзүүлсэн амжилт харьцангуй бага байна.

4.4.3. Сургуулиас үзүүлж буй урамшуулал, дэмжлэг

Тайлантай танилцахад: УБ хотоос 500км-ээс илүү зам туулан ирж, суралцаж буй оюутанд замын зардлыг зохих журмын дагуу сургалтын төрийн сангаар дамжуулан 2014-2015 онд 18, 2015-2016 онд-12 оюутанд буцаан олголт өгсөн. Сүүлийн 3 улирлын сурлагын дүнгээр голч оноо хамгийн өндөр “А” үнэлгээтэй, СУИС-ийн хэмжээнд тэргүүлсэн байх, Урлаг, спортын тэмцээн уралдаан болон нийгэмд хандсан үйл ажиллагаанд сургуулийн нэрийн өмнөөс удаа дараа амжилттай оролцсон, манлайлан зохион байгуулсан байх; Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд амжилт гаргаж, улсын хэмжээнд шагналт байранд, СУИС-ийн хэмжээнд тэргүүн байранд шалгарсан байвал Захирлын нэрэмжит тэтгэлэг олгодог.

Нэр төрөл	2015	2016	2017	2018 он	Нийт зардалд эзлэх хувь			
				төсөв	2015	2016	2017	2018
Оюутны замын зардал	4,962	2,988	4,226	4,226	0.24%	0.15%	0.18%	0.19%

Уулзалтаар: Хөдөө орон нутгаас суралцаж буй оюутнууд замын зардлаа авсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Болзол хангасан оюутанд СУИС-ийн захирлын нэрэмжит тэтгэлэг олгодог.
- 2016-2017 оны хичээлийн жилд БУБ хөтөлбөрийн суралцагчдаас СУИС-ийн захирлын нэрэмжит П.Отгонтуяа тэтгэлэг, н.Оюунханд Хаан банкны нэрэмжит тэтгэлэг авсан.
- 2013 оноос хойш 57 оюутанд 5078300₮ замын зардал олгосон байна.
- 2015-2016 оны байдлаар 30 оюутан Смарт картын үйлчилгээнд хамрагдсан.

4.5 Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

4.5.1. Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэсэн байдал

Тайлантай танилцахад: Оюутны шилжилт хөдөлгөөнийг 3 үе шаттай шийдвэрлэдэг. Шилжилт хөдөлгөөнийг 4 тохиолдлоор хийдэг.

Уулзалтаар: Зөвхөн сургууль дотроо төдийгүй өөр улсаас ирж суралцаж буй оюутнууд ч байдаг.

- Жилийн чөлөө авсан 19,
- Үргэлжлүүлэн суралцах 26,
- Хөтөлбөр мэргэжлийн чиглэлээ өөрчилсөн 18,
- Шилжиж ирсэн 3,
- Сургуулиас чөлөөлөгдсөн 20 оюутны асуудлыг шийдвэрлэсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “СУИС-ийн дүрэм, журам”-ын эмхэтгэл, “Оюутны гарын авлага” тодорхой оруулж өгсөн.
- Оюутны шилжилт хөдөлгөөнийг оюутанд чөлөө олгох сургуулиас чөлөөлөх, оюутны шилжилт, оюутныг үргэлжлүүлэн суралцуулах гэсэн шийдвэрлэх үе шаттай.

4.5.2. Шилжилт хөдөлгөөний судалгаа, дүгнэлт

Тайлантай танилцахад: Сурлагаар хоцрогдож буй оюутнуудын шалтгааныг тодруулан ангилсан. 2013 оноос хойш нийт шилжилт хөдөлгөөний шийдвэрлэлтийн судалгаатай.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага: Шилжилт хөдөлгөөнд 2011-2016 онуудын элсэгч, төгсөгчдийн судалгаа гаргасан.

Дүгнэлт: Хөтөлбөрийн шилжилт хөдөлгөөний судалгаа, дүгнэлттэй.

4.5.3. Шилжилт хөдөлгөөнийг зохицуулж буй дүрэм, журам, гэрээний хэрэгжилт, суралцагчийн эрх ашгийг дээдэлсэн байдал

Тайлантай танилцахад: “СУИС-ийн бакалаврын сургалтын журам”¹⁴аар зохицуулдаг.

- “СУИС-ийн дүрэм, журам” эмхэтгэл 2015 он
- Тэнхимийн үйл ажиллагааны тайлан мэдээ
- Оюутны холбооны төлөвлөгөө, тайлан
- Сургуулийн захирлын тушаал
- Дүнгийн мэдээ 2011-2016 он

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага: СУИС шилжилт хөдөлгөөнийг зохицуулах эрх зүйн баримт бичгүүдтэй.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

ШАЛГУУР 5. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

5.1 Багшийн сонгон шалгаруулалт, албан тушаал, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

¹⁴ “СУИС-ийн дүрэм, журам” эмхэтгэл 2015 он

Үзүүлэлт нотолгоо:

5.1.1. Сонгон шалгаруулалт, хөгжүүлэлт, төлөвлөлт, хэрэгжилт

Багш урлагийн боловсрол хөтөлбөр нь сургалтын арга зүйн өндөр чадвартай, соёл урлагийн болон боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан мэргэжлийн туршлага бүхий багш нарын бүрэлдэхүүнтэй. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багшийн сул орон тоо гарсан үед хүрэлцэхүйц нөөцийг бүрдүүлэхийн тулд шаардлага хангасан багш нарыг нөөцөд бүртгэн авдаг бөгөөд энэ нь сул орон тоо гарсан үед сонгон шалгаруулалт хийх нөхцөлийг бүрдүүлж байдаг байна. Мөн хөдөлмөрийн заах зээлд анализ хийх, хүний нөөцийн зөв бодлогыг дэмжиж хөгжүүлэх, сургалт зохион байгуулах ажиллагааг төгсөгчдийнхөө дунд явуулдаг байна. Багшийг сонгон шалгаруулах тухай мэдээллийг сургуулийн цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нээлттэй явуулж байгаа ба шалгаруулалтыг СУИС-ийн тэнхимд тавигдах шаардлага, профессор багш ажиллуулах журмын 3,6,8,10-р бүлэгт үндэслэн явуулдаг байна. Шалгаруулалт явуулахад эрдмийн зэрэг цол, өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт, багшлах арга зүй, ур чадвар, багш сонгон шалгалтын оноо, гадаад хэлний мэдлэг, ярилцлага зэргийг харгалзан авдаг байна. Мөн гадаад, дотоодын их дээд сургуульд нарийн мэргэжил эзэмшсэн уран бүтээлчдийг сургуулийн бодлогоор урин ажиллуулдаг байна.

5.1.2. Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа байгаа багш нарын бүрэлдэхүүнд одоогийн байдлаар докторын зэрэгтэй байгш байхгүй байна. Харин докторантурт суралцаж, судалгаа хийж байгаа 5 багш байна. Эрдмийн тэргүүлэх зэрэгтэй багш нарын эзлэх хувь өсөхгүй байна. Иймд сургуулиас ойрын хугацаанд докторантурт суралцах багш нарыг дэмжих, сургалтын төлбөрийн зохих хөнгөлөлт үзүүлэх, бүтээлийн чөлөө олгох, өндөр хөгжилтэй орнуудад залуу эрдэмтдийг сургах зэрэг ажиллагааг төлөвлөн ажиллаж байна.

5.1.3. Багш суралцагчдын тооны зохистой харьцаа

Өнөөгийн байдлаар тус хөтөлбөрт үндсэн 12, цагийн 5, бусад салбар тэнхимээс 8, ерөнхий суурь хичээлийн 25 багш хамтран ажиллаж байна. Тайланд 2012-2017 жилүүдэд ажиллаж байгаа нийт багш нарын тоо, өдрийн болон эчнээ оюутнуудын тоотой харьцуулсан судалгааг хүснэгтээр танилцуулжээ. 2016-2017 оны хичээлийн жилд нэг багшид ноогдох оюутны тоо 1:10 байна. Энэ хүсэгтээс харахад нэг багшид ноогдох оюутны тоо 6-10 байгаа ба энэ нь багш оюутанд хүрч ажиллах боломжийг бүрдүүлж байна гэж үзэж болно. Ганцаарчилсан хичээл, жишээ нь төгөлдөр хуур, үндэсний хөгжмийн хичээлүүдийг нэг багш нэг оюутан, нэг оюутан хоёр багш гэсэн харьцаатай байдаг нь тухайн хөтөлбөрийн онцлогийг харуулж байна.

5.1.4. Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг мөрддөг байдал

СУИС-ийн тавигдах шаардлага, профессор багш ажиллуулах журмыг баримтлан тэргүүлэх профессор, профессор, дэд профессор ахлах багш, багш, дадлагажигч багшийн албан тушаалын зэрэглэлд хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулдаг байна. Багш нар нь албан тушаалын зэрэглэлд тавигдах ерөнхий ба тусгай шаардлагыг даган мөрдөж ажиллах үүргийг хүлээж ажилладаг байна. Тайлангийн 78-р хүснэгтэд тус хөтөлбөрийн багш нарын албан тушаалын зэрэглэлийг харуулжээ. 2016-2017 оны хичээлийн жилд дэд профессор 1, ахлах багш 7, багш 4, гэрээт багш 2 ажиллаж байна. Гэрээт багш нарын сургалтын үйл ажиллагааг чанартай явуулах зорилгоор сургуультай гэрээ байгуулан ажиллуулдаг байна.

5.1.5. Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг урамшуулдаг байдал

СУИС-ийн захирлын 2015 оны 6-р сарын 5-ны өдрийн А147 дугаар батлагдсан “СУИС-ийн профессор багш, ажилтныг шагнаж урамшуулах журам”-ийг мөрдлөг болгон ажиллаж байна. 2014-2016 онуудад нийт 8 багш төрийн болон яамны шагнал хүртсэн байна. Мөн сургуулийн нэрэмжит шагналуудад тус хөтөлбөрийн багш нараас хамрагдаж, цалингийн хувийн урамшуулал хүртсэн байна. Тайланд сүүлийн гурван жилийн байдлаар багш нарт олгосон урамшууллыг хүснэгтээр харуулсан байгаа ба нийт 5%-20% хүртэлх урамшуулал олгогдсон байна. Багш нарт олгодог урамшуулалт цалин тогтмолжсон байгаа ба багш нарын ажлын гүйцэтгэл, үр дүнгээс шалтгаалан харилцан адилгүй хэлбэлзэлтэй байна. Багш нарын нэг кредитийн үнэлгээ 142,728 төгрөг, нормоос давсан илүү цагийн хөлс 109,296 төгрөгөөр тооцогдон олгогдож байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага: Дээд боловсролын тухай боловсролын тухай, СУИС-д профессор багш ажиллуулах журмын хүрээнд магистраас дээш зэрэг цолтой багшийг нээлттэй сонгон шалгаруулж авч байна. Хөтөлбөрийн онцлогоос шалтгаалан багшлах боловсон хүчний дийлэнхи хувь нь тус хөтөлбөөр амжилттай суралцаж төгссөн төгсөгчид, мөн гадаад орнуудад хөгжмийн багш, консерваторийн боловсрол эзэмшсэн багш нар ажиллаж байна. Мөн багш нар багшийн хөгжлийн хүрээнд өөрсдийнхөө мэдлэг чадварыг сайжруулан ажиллаж байгаа нь тус сургууль дээр зохиогдож буй, тус хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудын тоглолт, уран бүтээлээр харагдаж байна.

Зөвлөмж: Багш нарын мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг улам сайжруулах, гадаадын ижил төстэй хөтөлбөрүүдэд багш нарыг урт, богино хугацааны сургалтанд хамруулах

5.2.Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

5.2.1. Багшийн мэргэжил; заах арга зүйн ур чадвар; эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшин; суралцах хэрэгцээг тодорхойлох судалгааг тогтмол хийдэг байдал

Тайлантай танилцахад жил бүр багш нараас мэргэжил, заах арга зүй, ур чадвар, эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшин, суралцах хэрэгцээг тодорхойлох судалгаа авч судалгааны үр дүнд тулгуурлан багшийг хөгжүүлэх сургалт семинар, хичээлүүдийг зохион байгуулдаг байна. Тус хөтөлбөрийн багш нар нь хөгжмийн бүтээлийг өргөн хэрэглээний программууд зохиох болон ашиглах өндөр чадвартай байна. Тайлангийн 81 хүснэгтэнд мэргэжил дээшлүүлэлт, гадаад хэлний мэдлэг, гадаад дотоодын сургалтуудын талаар багш нарын санал, сурсан хугацааг харуулжээ.

5.2.2. Багшийн хөгжлийн хөтөлбөр, хэрэгжилт, дүн шинжилгээ, сайжруулалт

Тайлантай танилцахад хөтөлбөрийн багш нарын хөгжлийг дэмжих 8 зорилт дэвшүүлэн, гурван үе шаттай хэрэгжүүлж байна. Багшийн хөгжил нь тасралтгүй хөгжих үйл явц ба үе шатуудад хуваан хэрэгжүүлж байгаа нь үйл явцыг тодорхой, мөн зорилттой болгож байгаа нь харагдаж байна. Тайланд СУИС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн сургалт семинарын хуваарийг тусгасан байна. Мөн хөгжлийн ажлын хүрээнд багш нарт докторантурт суралцах төлбөрийн 20-40 хувийг зээл хэлбэрээр олгож байгаа бөгөөд одоогоор 5 багш докторантурт суралцан кредитээ цуглуулсан байна.

5.2.3. Багшийг үе шаттай хөгжүүлж, урт богино хугацаанд мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлж чадавхжуулдаг байдал

Багш нарыг сургуулийн зардлаар болон төслийн хөрөнгөөр гадаад дотоодод судалгаа шинжилгээний ажил хийх, уран бүтээл туурвих нөхцөл байдлаар ханган ажиллаж байна. Жишээ нь багш Ж.Төгсжаргал ОХУ-д эрдэм шинжилгээний хурал болон найрал дууны бүтээл туурвиж их наадамд оролцсон байна. Мөн багш нарт зориулсан эрдэмтдийн их

семинарыг 2013 оноос жил бүрийн хавар, намар тогтмол зохион байгуулж байгаа нь багш нарын мэргэжлийн ур чадвар, судалгааны арга зүй дээшлэхэд нөлөөлж байна. Ахмад туршлагатай профессор багш нарын лекцийг тогтмол явуулдаг нь сургууль багш нарынхаа мэдлэг ухааныг өвлүүлэн үлдээж байгаа оюуны томоохон хөрөнгө оруулалт юм. Ахлах багш Ч.Оюунцэцэг, Ж.төгсжаргал нар нь залуу багш нарыг дагалдуулан зөвөлгөө гөч, дадлага туршлагаа өвлүүлэн ажиллаж байна.

5.2.4. Гадаад, дотоодод туршлага судлуулсан байдал

БУБ хөтөлбөрийн багш нар нь 2014 оноос хойш Япон, БНХАУ, ОХУ, Малайз зэрэг орнуудад 8 удаа мэргэжил дээшлүүлэх богино хэмжээний сургалт, урлагийн их наадамд оролцож тэргүүн байр болон дэд байруудыг хүртсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага: Багшийн мэргэжил, заах арга зүй, эрдэм шинжилгээ судалгааны арга зүйн түвшин, сургалцах хэрэгцээг тодорхойлох судалгааг тогтмол хийдэг байна.

Зөвлөмж: Судалгааны ажлыг эрчимжүүлэх, “Багшийн хөгжил” хөтөлбөрийн хэрэгжилтийг улам сайжруулах, энэ хүрээнд гадаад дотоодын их дээд сургуулиудад багш нарыг мэргэжил дээшлүүлэхэд туслах, төсөл хөтөлбөрт хамруулах, багш нарын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд сургалтанд суухад дэмждэг үзүүлэх

5.3.Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

5.3.1. Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патентийн тоо

Багш И.Болормаа нь Оюуны өмчийн газраас “Аргил шударга” хөгжмийн зэмсэг технологийн шинэчлэл патентыг 2015 онд авсан байна. Багш Ж.Мөнхбат, Х.Баасансүрэн, Ж.Төгсжаргал, М.Цэнгэлсайхан, И.Болормаа, Ч.Оюунбилэг нар нь сурах бичиг, гарын авлага зохион туурвиж БУБ хөтөлбөрийн сургалтанд хэрэглэгдэж байна. Мөн багш нарын эрдэм шинжилгээний хурлуудад олон илтгэл бэлтгэж тавьж байгаа нь шинжлэх ухааны шинэ туршилт болж байна.

5.3.2. Захиалгат төсөл, гэрээт ажилд оролцсон байдал

2012-2013 оны хичээлийн жилд БСШУЯ-ны гэрээгээр ЕБС-ийн хөгжмийн сургалтын “Хөгжим-ҮИ” сурах бичиг болон багшийн ном зохиох ажилд багш Ч.Оюунбилэг ахлагчтай зохиогчийн баг шалгаран ажиллсан байна. Одоогоор энэхүү сурах бичиг нь үндэсний хэмжээнд ашиглагдаж байна. Тус хөтөлбөрийн багш нарын бүтээл болох 12 сурах бичиг, “Урлаг” цөм хөтөлбөр зэрэг нь улсын хэмжээнд үр дүнтэй ашиглагдаж байна.

5.3.4. Судалгааны ажлын үр дүнгээр хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүй; судалгааны ажил шинэчлэгдэн хөгжсөн байдал

БУБ хөтөлбөрийн багш нар нь судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэж, судалгааны үр дүнг сургалтандаа хэрэглэж байгаа нь багш нарын авсан оюуны өмчийн газрын патент, суралцагсдын хөгжимдөх чадварт тохируулан бүтээсэн зохиолын эмхэтгэл, сургалтын хөтөлбөрт тусгагдсан урын сангийн эмхэтгэл зэргийг хэвлэн ашиглаж байгаагаар харагдаж байна. Мөн багш нарын бүтээлд гадаадын орнуудын хөгжмийн боловсролын онцлог талуудыг ашиглаж өөрсдийн зохиол бүтээлд ашигладаг нь харагдаж байна. Энэ нь шинэчлэгдэн хөгжүүлэх ажлын үр дүн бөгөөд мөн багш нарын мэргэжил, мэдлэгт хувь нэмэр оруулахуйц бүтээлүүд болж байна.

5.3.5. Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн байдал

Багш Ж.Төгсжаргал, Г.Оюунтуяа, Ч.Оюунбилэг нар нь гадаад дотоодын сэтгүүлд өгүүлэл нийтлүүлж, Монголын үндэсний телевизээр захиалгат нэвтрүүлэг бэлдэн ажиллажээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага: Хэрэгжүүлсэн төсөл, захиалгат болон гэрээт ажлын үр дүнгээр багш нар бакалавр, магистрын шатны сургалтыг зохион байгуулах, оюутнуудад арга зүй эзэмшүүлэх, судалгааны ажил бичих, хамгаалах боломж бүрдсэн байна. Захиалгат болон гэрээт ажил нь хөтөлбөрийн онцлогт тулгуурласан судалгааны ажлууд байгаа ба оюутнуудад чадвар эзэмшихэд нь чухал үүрэг гүйцэтгэж байна.

Зөвлөмж: Боловсролын болон судалгааны ажлуудын патентын тоог нэмэгдүүлэх, энэ нь цаашид судалгаанд суурилсан их сургуулийн хөгжилд түлхэц болох талтай

5.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Үзүүлэлт нотолгоо:

5.4.1. Өөрийн үнэлгээний тайлан

БУБ хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад багш нар 2 жил тутам өөрийн үнэлгээний тайлан бичиж, түүнд тулгуурлан багшийн үйл ажиллагааг хянаж үнэлэх, урамшуулах, засан сайжруулах ажил тогтмол хийгдэж байна. Тайланд багш нарын өөрийн үнэлгээний тайлангийн бүтцийг харуулсан байна. Багш нарын өөрийн үнэлгээний тайланг үзүүлэлт тус бүрээр дүгнэсэнийг харахад 55% сургалтын үйл ажиллагаа, 25% нь эрдэм шинжилгээний ажил, 8 % нь уран бүтээл, 12% нь нийгмийн үйлчилгээ, зөвлөх үйл ажиллагаа, хувь хүний хөгжил гэсэн хариу гарсан байна.

5.4.2. Багшийн хөндлөнгийн үнэлгээ /Аттестатчлал, эрэмблэлт, чансаа тогтоолт/

Хоёр жил тутамд багш нарын дунд аттестатчилал явуулж зэрэглэл ахиулах, бууруулах, шагнал урамшуулал олгох зэрэг үйл ажиллагааг явуулж байна. Багшийг аттестатчлахдаа өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийдэг байна. Үйл ажиллагааны үндсэн чиглэлийг дараах байдлаар тодорхойлж шалгуур үзүүлэлтийг боловсруулсан байна. Үүнд: сургалтын үйл ажиллагаа, Эрдэм шинжилгээний ажил, уран бүтээл нийгмийн үйлчилгээ, зөвлөх үйл ажиллагаа, хувь хүний хөгжил. Хүснэгт 89, 90 нь 2012, 2015 онуудын БУБ хөтөлбөрийн багш нарын аттестатчлалын дүгнэлтийг харуулжээ.

5.4.3. Сургалтад ашиглаж буй сургах/заах аргын үр дүн, үр нөлөөний судалгаа

Багш нарын сургалтандаа ашиглаж байгаа сургах, заах аргын үр нөлөөг илүү тодорхой болгох үүднээс багш тус бүрээс ярилцлагын аргаар судалгаа авсан байна. Ер нь багш нарын арга зүй нь харилцан адилгүй байгаа гэдэг нь ойлгомжтой ба энэ нь ганцаарчилсан хичээл, ерөнхий суурь гээд хичээлүүдийн онцлогтой холбоотой юм. Багш нарын ярилцлагаас үзэхэд хосолсон арга, оюутан бие биедээ заах, хэлэлцүүлэх, засан сайжруулах, оюутны бие даан ажиллах гэх мэт аргуудыг дурьджээ.

5.4.4. Тайлан, судалгааг хэлэлцэж, дүгнэлт гаргасан байдал

Хичээлийн жилийн төгсгөлд багш нар ажлын тайлангаа бичиж тэнхимээр хэлэлцүүлдэг байна. Тайлангийн бүтэц нь сургалтын үйл ажиллагаа, эрдэм шинжилгээ судалгааны ажил, уран бүтээлийн ажил, хичээлээс гадуурх ажил гэсэн 4 хэсгээс бүрддэг байна.

5.4.5. Сургалтад оролцогчдоор багшийг үнэлүүлэх

Сургалтын алба, сургалтын бодлого зохицуулалтын газраас багшийн сургалтын үйл ажиллагааг хөндлөнгөөс үнэлэх үйл ажиллагааг тогтмол хийж ирсэн байна. Хүснэгт 91-ээс 2016-2017 оны намрын улиралд БУБ-ын оюутнуудаас авсан судалгааны үр дүнг харуулжээ. Судалгаа нь 6 асуулттай, асуулт тус бүр нь 4 хариултын сонголттой байна. Энэхүү судалгаа нь багш нарын өөрийн үнэлгээнд тодорхой нөлөө үзүүлж байна.

5.4.6. Багшийн бүхий л үйл ажиллагааны баримт, материал

Багш бүр өөрийн заадаг хичээлээр хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлдэг байна. Мөн багш бүр өөрийн боловсруулсан хөтөлбөрийг засан сайжруулах, шинэчлэх ажлыг тогтмол хийдэг байна. 2014 оноос сургалтын хөтөлбөрийн шинэчлэлтэй холбоотойгоор хөтөлбөр боловсруулах, боловсронгуй болгох үйл ажиллагаа эрчимжлсэн байна. БУБ-ын багш нар нийт 82 хөтөлбөр боловсруулсан мэдээлэл тайлангийн 92-р хүснэгтэнд харуулжээ. Мөн багш нар “Багшийн дэвтэр” ашиглаж, UNICULTURE системд өөрийн заасан хичээлийн үнэлгээг хичээл оюутан тус бүрээр оруулж сургалтын албаар баталгаажуулдаг байна.

Онцлог зүйл/Туршлага: Багш нар өөрийгөө үнэлэхдээ 90 ба түүнээс дээш хувиар үнэлсэн байна. Жил бүр хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын өөрийн үнэлгээний тайланг тэнхим, сургуулийн хэмжээнд хэлэлцэж, цаашид авах арга хэмжээ, алдаа дутагдал, сайжруулах шаардлагатай үзүүлэлтийн талаар санал зөвлөмж гарган ажиллаж байна.

Зөвлөмж: Багшийн хөндлөнгийн үнэлгээний журмыг сайжруулан боловсруулж нийт багш нарт танилцуулах, оюутны сэтгэл ханамжийн судалгааг багшийн үйл ажиллагаатай холбон ил тодоор хэлэлцүүлэн ажиллах

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

ШАЛГУУР 6. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

6.1. Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Үзүүлэлт нотолгоо:

6.1.1. Оролцогч болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээ ба агуулгын харьцуулсан шинжилгээ

“Багш, дуу хөгжмийн багш”, “Багш, урлагийн боловсрол” хөтөлбөрөөр суралцаж төгссөн төгсөгчдөөс тухайн хөтөлбөр нь зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцтэй эсэх талаар санал асуулга авахад онолын мэдлэг 97 хувиар, ур чадвар 72 хувиар тус тус шаардлага хангаж байгааг тусгажээ. Цаашид сургалтын агуулгад даралтат хөгжим төдийгүй хэд хэдэн үндэсний хөгжим, цахилгаан хөгжмүүдтэй ажиллах ур чадварыг олгох шаардлагатай гэж дүгнэсэн байна.

2011 болон 2016 оны сургалтын төлөвлөгөөнүүдийг харьцуулахад сурган хүмүүжүүлэх сэтгэл судлалын агуулга 3 кредитээр, хөгжмийн сургалтын арга зүйн хичээлүүд 3 кредитээр нэмэгдсэн байгаа нь сургалтад оролцогчдын хэрэгцээнд нийцүүлсэн шийдэл болжээ.

2016 онд сайжруулсан хөтөлбөр нь хичээлийн агуулгын давхардлыг арилгаж, багцалсан, төгсөгчийн ажлын байрны шаардлагыг хангахад чиглэсэн, багш боловсролын агуулгыг нэмэгдүүлсэн, арга зүй, ур дүйг сайжруулахад чиглэгдсэн олон шийдлийг тусгасан талаар тайлбарлав.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.1.2. Сургалтын агуулга нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцсэн байдал

Тайлантай танилцахад: Хөтөлбөрийн сургалтын агуулгыг 1. Ерөнхий суурь хичээлийн багц 2. Багш боловсролын багц 3. Хөгжмийн суурь ухааны багц 4.Хөгжимдөх урлагын

хичээлийн багц, 5. Найрал дуу-удирдаачийн багц зэрэг өөр хоорондоо залгамж холбоотой багцад хувааж, агуулгын давхардлыг арилгасан байна.

Бодит байдалтай танилцахад: “Багш урлагийн боловсрол” хөтөлбөрийн сургалтын үр дүнгүүдийг 3.1 дэх хэсэгт 4 хэсэгт ангилан тодорхойлж, хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөөнд сэдвийн агуулга, олгох мэдлэг чадварыг нэг хүснэгтэд тусгасан байна.¹⁵

Уулзалтаар: Хөтөлбөр нь нийт 84 хичээлийн агуулга бүрээр суралцагсдад шинжлэх ухаан, мэдээлэл, технологийн ололтыг сургалтад нэвтрүүлэх, сургалтыг олон улсын түвшинд ойртуулах, суралцагсдын эрэлт хэрэгцээ, шаардлагыг хангаж багш боловсролын онол арга зүй, мэргэжлийн ур чадвар болон хөгжмийн боловсролын олон талт үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад шаардлагатай агуулгыг олгож байгаа хэмээн тайлбарлав.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж: Цаашид хичээл нэг бүрээр CLO буюу хичээлийн сургалтын үр дүнгүүдийг нарийвчлан гаргаж, агуулга ба хүрэх үр дүнгийн матриц боловсруулж, мөрдөхийг зөвлөмжилж байна.

6.1.3. Суралцагч хичээл, багшийг сонгон суралцдаг байдал

Тайлантай танилцахад: 2011 оноос СУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын сургалтын үйл ажиллагаа нь удирдлагын мэдээллийн систем /UNICULTURE/-д нэгдсэнээр оюутан бүр өөрийн суралцах үйл явцыг хянах, хичээл, өдөр, цаг, багшаа сонгох, төлөвлөлт хийх боломжтой болсон гэж тайлагнасан байна. Хичээл сонголт 2 үе шаттай явагдана. 1. Судлах хичээлээ сонгож, захиалга өгөх, 2. Хичээлийн хуваарь, багшаа сонгож баталгаажуулна. 2011-2015 онуудын хичээл сонголтын явцыг 6 үзүүлэлтээр харьцуулснаас сүүлийн жилд суралцагч хичээл сонголтыг дангаараа бусдаас хамааралгүй хийх боломжтой болсон гэж харагдана. Нийт судлах хичээлийн 7,8 хувь нь сонгон судлах хичээл гэсэн судалгаа байна.

Бодит байдалтай танилцахад: Багш, оюутны вебээр нэвтэрч харахад оюутнууд ерөнхийдөө сонголт хийдэг боловч анги танхим, хөгжмийн зэмсгийн хүртээмжээс шалтгаалан хичээл сонголт ганцаарчилсан сургалтын хүрээнд нилээд хүндрэлтэй байгаа нь харагдав. Зарим ерөнхий суурь хичээлийг бүлгээр сонгож судалдаг байна.

Уулзалтаар: Хичээл, багш сонголтыг мэргэжлийн болон мэргэжлийн суурь хичээлүүдийн хүрээнд өргөн сонголттой болгож, хөгжмийн ур чадвар, багшлахуйн ур чадвар олгох хичээлүүдийг түлхүү нэмсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.1.4. Хөтөлбөр дэх хичээлийн хэлбэр, онол, практикийн зохистой харьцааг хангасан байдал

Тайлантай танилцахад: Уг хөтөлбөр нь лекц, семинар, ганцаарчилсан ур чадварын хичээл, дадлага гэсэн хэлбэрээр хичээлээ зохион байгуулдаг. Онол практикийн хувьд лекцийн хичээлийн хэлбэр 59,9 кредит, 73,5 кредит нь ганцаарчилсан болон найрал дуу, найрал хөгжмийн хичээлүүд эзэлдэг байна.

Бодит байдалтай танилцахад: Найрал дуу хичээлийн хөтөлбөр нь 32 цагийн семинар хэлбэрээр 2 дугаар улиралд судлахаар төлөвлөгдсөн бөгөөд “Соноршуулга I”, “Хөгжмийн онол I” хичээлүүдэд суурилан бүлгээр хичээллэж байна.

Уулзалтаар: Ганцаарчилсан хичээл явуулахад анги танхим, хөгжмийн зэмсгийн хүрэлцээ бага байдаг тухай ярилцав.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

¹⁵ Найрал дуу I /CHOIR I/ хичээлийн жишээн дээр

6.1.5. Үйлдвэрлэл, практик, клиник сургалтын агуулгыг хамтран хэрэгжүүлдэг байдал

Тайлантай танилцахад: Танилцах дадлага, туршин заах дадлага СӨБ, багшлах дадлага бага боловсрол, багшлах дадлага суурь боловсрол гэсэн хэлбэрээр дадлагын сургалтыг зохион байгуулдаг. Нийт сургалтын 13 кредитийг эзэлдэг. Дадлагын удирдамж, чиглэлтэй гэж тайлагнасан байна.

Бодит байдалтай танилцахад: Сүүлийн 5 жилд дадлагын сургалтыг цэцэрлэг, ЕБС, орон нутгийн соёлын төвүүд дээр зохион байгуулсан байна. Үүнд:

1. СӨБ-ийн 5, 24, 39, 42, 104, 105, 107, 129, 143, 4, 18-р цэцэрлэг
2. ЕБ-ын 1, 5, 23, 33, 39, 44, 45, 48, 50, 52, 54, 57, 65, 72, 84, 116, Шинэ эрин, Шинэ үе, Монгени цогцолбор, сургуулиуд
3. МҮЭСТО, Хан-уул дүүргийн соёлын төв, БЗД-ийн соёлын төв, БЗД-ийн Жанжин клуб, Чингэлтэй, Налайх дүүргийн соёлын төв, III цахилгаан станцын соёлын төв, Баян-Өлгий аймгийн Толбо, Дэлүүн сумын Соёлын төв, Сэлэнгэ аймгийн Шаамар сумын соёлын төв, Өвөрхангай Баян-өндөр сумын соёлын төв, Архангай аймгийн Цахир сумын соёлын төв, Булган аймгийн Рашаант сумын соёлын төв, Төв аймгийн Батсүмбэр, Партизан, Борнуур сумын соёлын төвүүдтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулж, дадлагын бааз цэцэрлэг сургуулийн 40 гаруй багшийг дадлага удирдагч багшаар сонгон ажиллуулсан. 4 төрлийн дадлага тус бүрээр СӨБ-ийн 10 цэцэрлэг, ЕБ-ийн 19 сургууль, мөн орон нутгийн 18 соёлын төвд нийт 630 оюутан дадлагын сургалтад хамрагдсан. Дадлага хийсэн сургууль, цэцэрлэгийн багш, оюутнаас 5 удаа судалгаа авч, хөгжмийн сургалтын арга зүй, төгөлдөр хуур, цахилгаан даралтат хөгжим зэрэг хичээлүүдийн агуулгад шинэчлэл хийсэн судалгаа байна. Дадлагын тайлан хамгаалалтын үзүүлэлт, дүнгүүдийг архивласан байна.

Уулзалтаар: Ажил олгогчид оюутнуудын дадлага аль аль талдаа их үр өгөөжтэйг онцлон тэмдэглэв. Тухайлбал, Шинэ үе сургуулийн дэд захирал 104 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Байгаль сүүлийн 10 жил 108 оюутны дадлага удирдсан. Цэцэрлэгийн 2,3 настны ангид дадлага хийлгэдэг. Оюутнууд ч заах арга зүй зэмшиж, цэцэрлэгийн бусад багш, хүүхдүүд шинэлэг арга барилтай танилцаж, урын сангаа баяжуулдаг гэв. 127 дугаар сургуулийн захирал Хүрэлбаатар ярихдаа 20 оюутны дадлагыг 2 сар гүйцэтгүүлэх явцад Монголын уламжлалт хөгжмийн зэмсэг “Хурган чих” хөгжмийг сурагчдад танилцуулж, тоглолт хийсэн. Өгөөжтэй болсон, цаашид сургуульдаа хөгжмийн багшийн дадлага авах сонирхолтой байгааг илэрхийлэв.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.1.6. Зайны болон цахим хичээлүүдийг E- контент түвшинд боловсруулан сургалтад ашигласан байдал

Тайлантай танилцахад: 2010 оноос техник хэрэгсэл, программ хангамжуудыг нэйтрүүлж, мэргэжлийн хөтөлбөрийн мэдээллүүдийг E-сургалтын хэлбэрт оруулан ажиллаж байгааг дурджээ. 2014 оны байдлаар бүх лекц, дадлага хичээлүүд PPT, зарим хичээлүүд видео хэлбэрт, бүх хичээл болон сурах бичгүүд E-book хэлбэрт, хөгжмийн хичээлүүд Sibeluis хэлбэрт шилжсэн байна. Мөн блог хаяг, facebook групп, E-mail хаягийг сургалтад ашигладаг тухай дурджээ.

Бодит байдалтай танилцахад: БУБ хөтөлбөрийн бүх багш “Багшийн веб”-д хичээлийн стандарт хөтөлбөр, хичээлийн агуулга, оюутны дүнгийн мэдээллээ оруулсан байна. Мөн

тестийн санг цахим сүлжээнд оруулснаар оюутан бие даан ажиллах боломж бүрджээ. БУБ хөтөлбөрийн багш нар Facebook групп үүсгэн оюутны бие даалтын ажил, хичээлээр судлах нэмэлт материал, аудио болон видео сонсох хөгжмийн уран бүтээл байршуулдаг байна.

Е-контент боловсруулах талаар: М.ІЕ301 кодтой Хөгжмийн сургалтын арга зүй I, М.ІЕ302 кодтой Хөгжмийн сургалтын арга зүй II, М.ІЕ303 кодтой Хөгжмийн сургалтын арга зүй III, М.ІЕ304 кодтой Танилцах дадлага, М.ІЕ306 кодтой Багшлах дадлага-Бага боловсрол, М.ІЕ307 кодтой Багшлах дадлага-Суурь боловсрол хичээлийн эх хэрэглэгдэхүүн болох хөгжмийн хичээлийн сурах бичгүүд (<http://econtent.edu.mn/content/library.html>) цахим хаяганд байршиж, нийслэл, орон нутгийн ЕБС-ийн багш, сурагчид, эцэг эх, сонирхон судлагчид, хөгжмийн боловсрол судлаачид, энэ чиглэлээр суралцагсад нээлттэй хэрэглэх боломжтой тавигдсан ба сургалт, судалгааны эргэлтэд хэрэглэгдэхүйц нээлттэйгээр байршсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж: Цаашид бүх нийтийн урлагийн боловсролд хувь нэмэр болохуйц хөгжим, дууны цахим хичээлүүдийг сургуулийн веб сайтад байршуулах, багш нарын боловсруулсан сургалтын Е-контентийн бодит судалгааг хийж тайландаа тусгах, шилдэг Е-контенттэй багш нараа шалгаруулж байхыг зөвлөж байна.

6.1.7. Хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хангасан байдал

Тайлантай танилцахад: Хичээлүүдийн агуулга, ур чадварын залгамж холбоог хичээлүүдийн танилцаж хийж тогтоосон. Тухайн хичээлийг судлахын тулд өмнөх холбоотой хичээлийг заавал судалж, амжилттай үнэлэгдсэн байхаар тогтоосон гэдгээ тайланд тусгажээ.

Бодит байдалтай танилцахад: Сургалтын хөтөлбөртэй танилцахад хичээлүүдийн залгамж холбооны танилцаж хийсэн байна. Ганцаарчилсан хичээлийн онцлогоос шалтгаалан улирал дамнасан хичээлүүд тусгасан байна.

Уулзалтаар: Багш нар багш боловсролын болон хөгжмийн боловсролын хичээлүүд өөр хоорондоо залгамж холбоотой байдаг тухай танилцуулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж: Хичээлийн хөтөлбөрийн боловсруулалтад хичээлийн залгамж холбоог тэмдэглэх, ээлжит хичээлийн боловсруулалтад агуулгын болон өмнөх дараах хичээлүүдийн залгамж холбоог тусгахыг зөвлөж байна.

6.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

6.2.1. Сургалтын арга зүйг боловсруулсан баримт бичиг, загвар

Тайлантай танилцахад: “Багш, урлагийн боловсрол” хөтөлбөрийн сургалтын арга зүйг хөгжмийн боловсролын орчин үеийн үзэл баримтлал, чиг хандлагад нийцүүлэн оюутны мэдэх бүтээх үйл ажиллагаанд тулгуурлах, сургалтын шинэлэг аргуудыг хэрэглэн сургах арга зүйн зарчмыг үндэслэн боловсруулан хэрэглэж байна хэмээн тэмдэглэжээ.

Бодит байдалтай танилцахад: Хичээлийн төлөвлөгөөнөөс харахад хөгжмийн ур чадварын хичээлүүд ганцаарчилсан хэлбэрээр зохион байгуулагддаг нь суралцагч төвтэй сургалтын арга зүйг хэрэгжүүлэх нэг нөхцөл бүрдсэнийг харуулна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Зөвлөмж: “Багш, урлагийн боловсрол” хөтөлбөрийн сургалтын арга зүйн нэгдсэн тогтолцоог нэгтгэж, арга зүйн заавар, загваруудыг хавсралтаар боловсруулахыг зөвлөө.

6.2.2. Сургалтад ашиглаж буй арга зүй нь мэдлэг бүтээлгэж, хэрэглэж сургахад чиглэсэн байдал

Тайлантай танилцахад: Тухайн хөтөлбөрт ашигладаг 20 төрлийн аргуудыг харгалзах багц хичээлүүдэд ангилан дүгнэлт хийжээ. Багш нарын сургалтын арга зүйг дээшлүүлэх зорилгоор үзүүлэх хичээл зохион байгуулж нийт багш нарын 64,2 хувийг хамруулжээ.

Бодит байдалтай танилцахад: Сургалтын арга зүйн хэрэглээг тодруулах зорилгоор 18/4/24-ний өдөр Хөгжмийн онол хичээл заадаг Ж.Төгсжаргал багшийн 2 дугаар дамжааны 19 оюутанд заасан семинарын хичээлд суув. Хичээлийн цагийн 80 гаруй хувьд оюутны оролцоог хангасан, идэвхтэй сургалтын аргуудыг ашиглав. Тухайн хичээлээр хөгжмийн онол, соноршуулга, зохирлын ухаан, хөгжмийн хэлбэр, хөгжмийн найруулга зэрэг хичээлүүдийн агуулгыг интеграцчилж, дэвшилтэт технологийн “Хөгжмийн ухаалаг самбар”-ыг ашиглан хичээл заалаа.

Мөн найрал дууны багш Л. Баяраагийн найрал дууны 2-3 хоолойн уран бүтээлийн семинарын хичээлд сууж, ажиглав. Оюутнууд найрал дууны онолын мэдлэгээ урлагийн бүтээл болгох, багаар хамтран ажиллах, тайзны сахилга батыг сахих, дуулалтын техникүүдийг бүрэн эзэмших ур чадварыг олгохуйц бүтээлч, идэвхтэй сургалтын арга зүйг ашиглаж байлаа.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж: Тухайн хөтөлбөрийн шилдэг, тэргүүний арга зүйтэй багш нарын туршлагыг хэвлэмэл байдлаар, багшлахуйн орчин үеийн онолоор тайлбарласан эмхэтгэл гаргахыг санал болгож байна.

6.2.3. Сургалтад хэрэглэж буй мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, программ хангамж, техник хэрэгслийн ашиглалтын судалгаа

Тайлантай танилцахад: Багш нараас авсан судалгаагаар нийтлэг болон тусгай хэрэглээний 11 төрлийн программ ашиглаж байна. Ялангуяа ноотны Sibeluis, дуу бичлэгийн Auda city, Cubase зэрэг программуудыг 91-32 хувийн үзүүлэлттэй ашиглажээ.

Бодит байдалтай танилцахад: Сургалтад стандарт программ хангамж бүхий нийт 32 компьютер хэрэглэж лан буюу утсан холболттой, WI-FI орчинтой интернетээр хангагдсан. Мөн мэргэжлийн дуу бичлэгийн студи байгуулан хэрэглээнд нэвтрүүлсэн байна.

Уулзалтаар: Жил бүр багш, суралцагчдын хэрэгцээг хангах зорилгоор техник хэрэгслийн хангамжийг сайжруулж, ухаалаг самбар, нотны программаар хангаж ирсэн. Улмаар нотны программ ашиглах арга зүйн хичээлийг хөтөлбөртөө тусган хэрэгжүүлж байгааг танилцуулав.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага: Дуу бичлэгийн студийн ажиллагаа, ухаалаг самбарыг дуу, хөгжмийн хичээл заахад ашиглах арга зүй, нотны программ ашиглах арга зүй зэрэг нь түгээн дэлгэрүүлэх туршлага байх боломжтой.

6.2.4. Сургалтын арга зүйн судалгаа, дүгнэлт, хөгжүүлдэг байдал

Тайлантай танилцахад: “Үзүүлэх хичээл” –ийг уламжлал болгон хэрэгжүүлж, сургалтын арга зүйг хөгжүүлэх, шинэ мэдлэг, чадвар, үр дүнтэй арга зүйн эрэл хайгуул хийж, төрөл бүрийн арга зүйг туршин ажиллаж байна. 2016 оноос тэнхим сурталчилах өдөрлөгийн хүрээнд СӨБ, ЕБС-ийн хөгжмийн хичээлийн арга зүйг сайжруулах талаар дадлагаар ажилласан оюутан, багш нарын оролцоотой хэлэлцүүлэг хийж эхэлсэн.

Бодит байдалтай танилцахад: Тэнхимийн ажлын хуваарийн дагуу 18/4/24-ний өдөр Хөгжмийн онол хичээлээр багш Ж.Төгсжаргал үзүүлэх хичээл зааж, хичээлд суусан багш

нар задлан шинжлэлтэй хэлэлцүүлэг хийв. Хэлэлцүүлгээр багшийн заах арга зүйн онцлог, үр өгөөж, хэрэглэгдэхүүний ач холбогдлыг ав хэлэлцсэн нь арга зүйн хөгжлийг хангахуйц тогтмол үйл ажиллагаа гэдгийг харуулж байна.

Уулзалтаар: Багш нар өөрсдийн хэрэглэдэг сургалтын арга зүйгээ үр дүнд суурилсан, бодит чадвар олгохуйц шавь төвтэй ганцаарчилсан арга зүйг ихэвчлэн ашигладаг хэмээн тодорхойлов. Тухайлбал “Хөгжмийн сургалтын арга зүй” хичээлээр асуудал дэвшүүлэн хэлэлцүүлэх, шийдвэрлэр арга замыг эрэлхийлэх, асуудлыг олон өнцгөөс харах чадварт сургадаг бол хөгжмийн онол, дуурьсахуйн онол хичээлүүдийг интеграцчилан багш боловсролын хэрэгцээнд нийцүүлэн заадаг, ноотны программыг оюутны бие даан суралцах арга барилтай хослуулан ээлжит хичээлд ашигладаг хэмээв.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж: Багшийн хичээлд анализ хийх төрөл бүрийн үзүүлэлттэй үнэлгээний хуудас боловсруулан ашиглах улмаар хөгжим заах арга зүйн чиглэлээр судалгааны илтгэл боловсруулж, өгүүлэл бичихийг зөвлөмжилж байна.

6.3. Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн дүүрэн, үнэлдэг арга зүйтэй, түүнийг байнга сайжруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

6.3.1. Мэдлэг, үр чадвар, хандлагын түвшин тогтоох, ахиц дэвшлийг үнэлэх үнэлгээний арга, аргачлал, хэрэглээ

Тайлантай танилцахад: 2014 оны 03 тоот тогтоолоор батлагдсан СУИС-ийн журмын дагуу тухайн хичээлийг заасан багшаар 70 хүртэл оноогоор, 30 хүртэл оноогоор улирлын шалгалт авдаг. Тухайн хөтөлбөрийн хувьд ганцаарчилсан хичээлийг дүгнэхдээ 50/50 хуваариар үнэлдэг байна. Багш нар UNICULTURE удирдлагын системд дүнгээ оруулдаг. Лекцийн хичээлийн мэдлэгийг тест, бие даалтаар, ганцаарчилсан хичээлийг дүгнэхдээ чадвар, хандлагыг голлон үнэлдэг хэмээжээ.

Бодит байдалтай танилцахад: UNICULTURE системд хичээлийн үнэлгээг улирал дараалан оруулж, голч дүнгийн муруйг гаргадаг байна. Харин тестийн сангийн баяжилт хийгдээгүй байна.

Уулзалтаар: Суралцагчаар өөрийн үнэлгээ хийлгэх зорилгоор шалгалтын дараа оюутан бүрээр алдаа, оноог нь задлан шинжлүүлэх, алдаан дээр нь ажиллуулж, залруулах ажил зохион байгуулдаг. Мөн үнэлгээгээ ахиулах боломжтой. Оюутан дүгнэгдсэн байдалдаа сэтгэл ханамжгүй байвал өөрийн хүсэлтээр тухайн хичээлд үнэлгээ тавиулж, дараа улиралд дүнгээ ахиулах боломжтойг танилцуулав.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж: UNICULTURE системд сорил, даалгаврын санг бүрдүүлж, 30 онооны шалгалтыг хөндлөнгөөс авах боломжийг бүрдүүлэхийг зөвлөмжилж байна.

6.3.2. Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл нэг бүрийн үнэлгээний арга, хэлбэр нь суралцагчдыг тасралтгүй хөгжихөд хөтөлдөг байдал

Тайлантай танилцахад: Хөтөлбөрийн судлагдахуунуудыг лекцийн хичээл, ганцаарчилсан хичээл, дадлагын хичээл гэж ангилаад ангилал тус бүрийн үнэлгээний задаргаанд дүгнэлт хийснээс харахад багш боловсролын багцийн хичээлүүдийн үнэлгээний арга нь бусадтай хамтран ажиллах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх чадварыг хөгжүүлдэг бол хөгжимдөх урлагийн багц хичээлүүдийн үнэлгээний арга нь хөгжим тоглох гамм, тэмдэгт, динамикийн тэмдэглэгээ нэмэгдэх, тональность сайжрах,

зохиол бүтээлийн төрөл, хэлбээр томорч, арга техник нарийсах зэргээр ур чадварыг нь хөгжүүлдэг байна.

Уулзалтаар: Багш нар багш, хөгжмийн боловсролын хөтөлбөрөөр суралцагсдыг хөгжүүлэхдээ үнэлгээний аргыг түгээмэл ашигладаг тухайгаа танилцуулав. Тухайлбал, хөгжмийн багшийн эзэмшвэл зохих хөгжимдөх чадвар, дуулах чадвар, хүүхдийн хөгжмийн сонголыг хөгжүүлэх чадвар, хөгжим сонсох үйл явцыг удирдах чадвар, хүүхэдтэй ярилцах чадвар, сургалтын техник хэрэгсэл ашиглах чадвар, хүүхдийн бие даах үйл ажиллагааг удирдах чадвар, үзүүлэн тараах материалын ур хийц, багшийн дүр төрх, ёс зүй зэрэг үзүүлэлтээр тусгайлсан үнэлгээг боловсруулан ажилладаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.3.3. Суралцагчийн үнэлгээ нь ил тод, найдвартай, шударга, ижил тэгш зарчмыг хангасан байдал

Тайлантай танилцахад: Оюутны мэдлэг, чадварыг үнэлэх журмыг оюутны гарын авлагад тусган түгээхийн зэрэгцээ сэтгэл ханамжийн судалгаагаар үнэлгээний ил тод, шударга, бодит байдалд үнэлгээ хийлгэж, дүгнэдэг. Багш, оюутнууд өөрсдийн вебээр нэвтрэн явцын болон шалгалтын дүнтэй танилцдаг хэмээсэн байна.

Бодит байдалтай танилцахад: СУИС-ийн <http://www.suis.edu.mn/teacher/> веб хуудсаар нэвтэрч үзэхэд суралцагчийн үнэлгээний задаргаа, сэтгэл ханамжийн судалгааны тоон боловсруулалт зэрэг нь бодитой, найдвартай ажиллаж байсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.3.4. Суралцагчийн гаргаж буй амжилтууд

Тайлантай танилцахад: Багш, урлагийн боловсрол хөтөлбөрөөр суралцагсдын голч дүнг бусад хөтөлбөрөөр суралцагсдын дүнтэй харьцуулахад ахицтай, хэлбэлзэл багатай, сүүлийн жилүүдэд өсөлттэй байгаа нь тэдний сурлагын амжилт тогтвортой дээшилснийг харуулж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

ШАЛГУУР 7. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

Хөтөлбөрийн үр дүн нь сургуулийн эрхэм зорилго, зорилтыг хангаж, сонирхогч талуудын эрэлтэд нийцсэн, үнэ цэнэтэй байна.

7.1. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

7.1.1. Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, ажлын байрны нийцлийн судалгааг тогтмол явуулж, хөтөлбөрийн шинэчлэлд тусгаж хэрэгжүүлдэг байдал

Тайлантай танилцахад: 2011 оноос хойш Багш урлагийн боловсрол мэргэжлийн хөтөлбөрийг 4 удаа шинэчилсэн бөгөөд хөтөлбөрийн үр дүнгийн судалгаа хийгдсэн.

Төгсөгчдийн ажил эрхлэлт, төгсөгчид, ажил олгогчдын сэтгэл ханамж, хөтөлбөрөөр төгсөгчдийн амжилтын судалгаанууд тус тус хийсэн.

2013 оноос хойш нийт 121 төгсөгч төгссөн бөгөөд хөтөлбөрийг туршин хэрэгжүүлж, үр нөлөөг тооцон нэмэгдүүлж, боловсронгуй болгох боломжтой.

Уулзалтаар: Хөгжмийн багшийн ажлын ачааллыг мэдэрсэн нэгжийн удирдлагууд багшийг дэмжиж сургалтын орчин, хэрэглэгдэхүүнээр хангахад хамтын ажиллагаа чухал гэдгийг ажил олгогчид онцлон хэлж байлаа.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- СУИС-ХУС-ийн “Монгол дэг сургалтаар олон улсын жишигт нийцсэн мэргэжлийн уран бүтээлч, судлаач багш бэлтгэх” эрхэм зорилгод нийцүүлж шинэчлэлийг сүүлийн 2 жилд хийж байгаа.
- Нийслэл, баруун, зүүн, хангайн, төвийн бүсийн харьцуулсан судалгаатай бөгөөд нийт хөгжмийн багшаар ажиллаж буй багш нарын 85-93% ажлын байраар хангагдсан.
- Төгсөгчдийн тоон үзүүлэлт жилээс жилд нэмэгдсэн.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн судалгаагаар багш нарын ажлын байран дахь бэрхшээлийн хувьд судалгааны ажлын арга зүй, найрал дуу, удирдаачийн ур зүй, мэргэжлийн дидактик хичээлийн агуулга, зохион байгуулалт, үр өгөөж, арга хэлбэрт анхаарч, албан хэрэг хөтлөлтийг суурь кредит хичээлээр оруулах хэрэгцээ шаардлагатайг цаашид анхаарах
- Төгсөгчдөөс авсан ажлын байрны нийцлийн судалгааны мөрөөр ажил зохион байгуулсан эсэхийг тодорхой болгох

Дүгнэлт: ЕБС-ийн хөгжмийн багшийн орон тооны бүсчилсэн судалгааг гаргасан нь цаашид БУБ хөтөлбөрөөр бэлтгэх боловсон хүчний бүсчилсэн хэтийн төлөвлөлттэй болсон байна.

Зөвлөмж: БУБ хөтөлбөрийн сургалтад багш, суралцагчдын хамтарсан сурах-сургах үйл ажиллагаа чухал үүрэгтэй бөгөөд хичээл зохион байгуулалт, багшийн заах арга зүй, мэдлэг, ур чадвар, шинэлэг бодит санаачилгыг хэрэгжүүлэх эерэг хандлагад чиглүүлэх агуулгыг илүүтэй тусгаж, төгсөгчдийн ажлын байрны нийцэлтэй уялдуулахад анхаарах

7.1.2. Төгсөгчид, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа

Тайлантай танилцахад: 2016 онд шинэ төгсөгч, олон жил ажилласан туршлагатай, дунд үеийн 26 багшийг санамсаргүй түүврийн аргаар сонгон 16 асуулт бүхий судалгаа авч нэгтгэсэн, дүгнэлттэй.

Уулзалтаар: Ажил олгогч талаас Олон улсын хөтөлбөртэй сургуулийн захирал Б.Амартүвшин, Баянзүрх дүүргийн гэр хороолол дахь 127 дугаар сургуулийн захирал С.Хүрэлбаатар, Шинэ үе төрийн бус өмчийн сургуулийн захирал н.Цэрэндолгор, 104 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Т.Байгаль, IOV Олон Улсын байгууллагын захирал н.Мөнхнасан нартай уулзахад: Хөгжмийн багш олон талын авьяастай, зохион байгуулах чадвартай, хүүхдэд хайртай багш боловсон хүчин бэлтгэхэд анхаарч ажиллах саналыг гаргаж байсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага:

- Ярилцлагад оролцсон ажил олгогчид 100% сэтгэл ханамжтай байсан.
- Төгсөгчид, багшийн ажлын үнэлэмж бага ч мэргэжилдээ дуртай, учраас сэтгэл хангалуун ажилладаг байна.

Анхаарах асуудал:

- Ажил олгогчид “21 дүгээр зууны багш” хүлээж авахыг хүсэн хүлээдэг тул төгсөгчид өөрийгөө хөгжүүлэх тал дээр анхаарч олон талын авьяас чадвараа суралцаж буй хугацаандаа хөгжүүлэхийг цаг үе шаардаж байна.
- Төгсөгчдийн өгсөн судалгаанаас харахад сургалтын агуулга нь амьдрал практикт бүрэн дүүрэн нийцэхгүй байна гэж 62.0% хариулснаас дүгнэхэд сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн агуулга, урын сангийн сонголтыг эргэж харах зайлшгүй шаардлагатай байна.

Зөвлөмж:

- Төгсөгчдийн хариулсан судалгаагаар: Судалгааны ажлын арга зүй, удирдаачийн ур зүй, мэргэжлийн дидактик зэрэг хичээлүүдийн агуулга, зохион байгуулалт, үр өгөөж, арга хэлбэрт онцгойлон анхаарах шаардлагатай бөгөөд архив, албан хэрэг хөтлөлтийн хичээлийг суурь боловсролын кредитэд оруулах саналыг судлах
- Ажил олгогчдын төлөөлөл бүхий төрийн болон төрийн бус 5 байгууллагын хүмүүстэй уулзахад төгсөгчдийн ур чадвар сайн байгаа ч ажлын байран дээр багш өөрийгөө хөгжүүлэх, сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг бэлтгэх чадварт суралцуулах тал дээр их дээд сургуулийн багш нар чиглүүлэн ажиллах
- “Эргэх холбоо” төгсөгчдийг давтан сургах үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах

7.1.3. Төгсөгчид ажлын байраар хангагдах хүртлээ хүлээхэд зарцуулах дундаж хугацаа

Төгсөгчдийн 91,3% нь 6 сарын дотор ажлын байртай болсон нь багш урлагийн боловсролын боловсон хүчний хангалттай шууд хамааралтай байна.

2015-2016 оны хичээлийн жилд Багш, урлагийн боловсрол мэргэжлээр 23 төгсөгчдийн 21 буюу 91.3% төгссөнөөс 6 сарын дотор ажлын байраар хангагдсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөдөө орон нутаг, нийслэлд хөгжмийн багшийн эрэлт хэрэгцээ их байна.
- 2014 оноос төгсөгчдийн ажлын байраар хангагдсан судалгааг хийсэн, дүгнэлттэй.

Анхаарах асуудал: Хөгжмийн багшийн боловсон хүчний эрэлт хэрэгцээ байгаа тул энэ хөтөлбөрөөр бэлтгэх элсэгчдийн тоог нэмэгдүүлэх

Дүгнэлт: Аймгийн боловсрол соёлын газар, нийслэлийн Боловсролын газарт албан бичгээр хандаж, сул ажлын байрны судалгаан дээр үндэслэн төгсөгчдийг богино хугацаанд ажлын байртай болгох боломжтой.

7.2. Хөтөлбөрийн үр нөлөө:

Хөтөлбөр үр дүнгээ үнэлүүлэх, үнэ цэнээ тодорхойлох, ахиц дэвшлээ харуулах нотолгоотой байна.

7.2.1. Хөтөлбөрөөр төгсөгчдийн амжилтууд

ЕБС-ийн дунд зохиогддог уламжлалт 10, мэргэжлийн багш нарын дунд 2, улс аймгийн чанартай 8 уралдаан тэмцээнд тогтмол амжилт үзүүлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Нийслэлд ажиллаж буй төгсөгчдийн тухайд мэргэжлийн чиглэлээр асууж тодруулах зүйл тулгарвал багш нартай биечлэн уулзах, онлайнаар холбогдон зөвлөгөө авах бүрэн боломжтой.

Дүгнэлт: Ажлын байрны судалгаа, тус сургуулийн түүхэн баримтаас үзэхэд нийслэл төдийгүй хөдөө орон нутагт БУБ хөтөлбөрийн төгсөгчдийн 99.2% нь ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсрол, соёлын төвд хөгжмийн багшаар ажиллаж байна.

Зөвлөмж: Багшлах боловсон хүчний эрэлт хэрэгцээ ихтэй байгаа энэ үед төгсөгчдийн амжилт, ололтыг сургуулийн вэб сайтад байршуулж түгээх, оюутнуудад төгсөгчдөөс суралцуулах ажлыг зохион байгуулах

7.2.2. Салбар, хөдөлмөрийн зах зээлд эзлэх байр суурь

2010-2014 онуудад төгсөгчдийн 97,2% мэргэжлээрээ ажиллаж байсан бол 2015-2016 оны хичээлийн жилд 99,2% болж өссөн байна. СУИС-ийн ХУС-иас төгсөгчдийн “Мөшгих судалгаа”-г төслөөр хийсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөдөлмөрийн зах зээлийн тандах судалгааг жил бүрийн хавар элсэлттэй хамт зохион байгуулдаг.
- Багш урлагийн боловсролоор бэлтгэсэн олон жилийн туршлага, сургалтын анги танхим, техник хэрэгсэл, хэрэглэгдэхүүнтэй.
- СӨБ, ЕБС-ийн дадлагын бааз, өндөр ур чадвартай багш, боловсон хүчнээр хангагдсан.
- СӨБ, ЕБС-ийн хөгжмийн хичээлийн үндэсний хэмжээний хөтөлбөр, сурах бичиг, баримт бичгүүдийг боловсруулсан багийн ахлагч, багийн гишүүд ажиллаж байна.

Анхаарах асуудал: Дуу хөгжмийн багш мэргэжлийн хөтөлбөрийг Сэрүүлэг, Газарчин, Дархан дээд сургуулиудад хэрэгжүүлж байгаа тул илүү чадварлаг багш бэлтгэх

Дүгнэлт: Хөдөлмөрийн зах зээлд БУБ хөтөлбөрийн төгсөгчдийн эзлэх байр суурь тогтвортой.

7.2.3. Мэргэжлийн салбарын хөгжилд оруулсан хувь нэмэр /Төрийн болон ТББ-ын зүгээс хийсэн үнэлгээ, судалгаа/

Тайлантай танилцахад: “Хөгжмийн багш-Соёлын хүн” хөтөлбөр, СӨБ, ЕБС, ИДС-д тус сургуулийн багш нарын зохиосон гарын авлага ашиглагдаж байна. Ялангуяа ЕБС-ийн 1-9 дүгээр ангийн хөгжмийн хичээлийн сурах бичгүүд, “Багшийн ном”-ыг хэрэглэж байна.

Бодит байдал дээр танилцахад: ХУС-ийн БУБ-ын тэнхим дээр ерөнхий боловсролын сургуулийн 1-9 дүгээр ангийн “ХӨГЖИМ” сурах бичиг, “Багшийн ном” зэргийг тогтмол ашиглаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тус сургуульд түүхэн алдартнууд олон бөгөөд тэдний ном бүтээлүүдийг сургалт судалгаандаа бүрэн ашигладаг.
- ЕБС-ийн хөгжмийн хичээлийн багш, сурагчдын сурах бичгийн зохиогч, боловсруулсан туршлагатай багш нар ажилладаг.

Дүгнэлт: Мэргэжлийн салбарын төрийн болон төрийн бус байгууллагаас хийсэн судалгаанд эерэг үнэлгээ өгсөн байна.

Одоогоор 20 орчим сургалтын байгууллагатай оюутны дадлага хийх, хичээл заах, БУБ хөтөлбөрийн бодлого чиглэлээр хангахад мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

7.3.1. Суралцаж буй гадаад оюутны тоо

Тайлантай танилцахад: 2016-2017 оны хичээлийн жилд ӨМӨЗО-ны 2, 2017-2018 оны хичээлийн жилд ӨМӨЗО-ны 1 оюутан багш урлагийн боловсрол чиглэлээр суралцаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ӨМӨЗО-ноос суралцагчдыг оюутны дотуур байранд амьдруулж, тэдний аюулгүй ээлтэй орчинд амьдрахад анхаарч ажилладаг.

Анхаарах асуудал: ХУС-ийн БУБ-д гадаад оюутан элсэх нь харьцангуй бага байдаг.

7.3.2. Олон улсын хамтарсан хөтөлбөрийн хэрэгжилт

Тайлантай танилцахад: Олон улсын Кембридж, Япон, Англи, ОХУ, АНУ, Швейцарийн сургалтын баримт бичгүүдэд судалгаа хийж, өөрийн орны онцлогт нийцүүлэн ЕБС-ийн хөгжмийн хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан.

Уулзалтаар: Япон улсын Токио хотын Их сургуулийн зөвлөх багштай хамтран ажиллахаар гэрээлж, 3 багшийг туршлага судлуулах зорилгоор явуулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Япон улсын Токио хотын их сургуулийн зөвлөх багштай хамтран ажиллах гэрээ байгуулж, 3 багшийг хамруулсан.
- Олон улсын хөтөлбөртэй сургуулийн хөгжмийн багш нарыг түшиглэж, төгсөх курсын оюутнуудыг дадлага хийлгэх бааз сургууль болгож хамтын ажиллагаатай ажиллаж байна.

Дүгнэлт: Бусад орны хөтөлбөрийг харьцуулж, ерөнхий боловсролын сургуульд судлах сурах бичгийн боловсруулалтад тусгаж оруулсан нь хөгжмийн багш мэргэжлээр ажиллаж буй багш нарын хамгийн эрэлт хэрэгцээтэй арга зүй болж чадсан.

7.3.3. Улсын болон олон улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд үзүүлсэн амжилт

Тайлантай танилцахад: 2013 оноос хойшх төгсөгчид нь улсын болон олон улсын чанартай 20 олимпиад, уралдаан тэмцээнд амжилт үзүүлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2013 оноос хойш төгссөн төгсөгчдийн улсын болон олон улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд үзүүлсэн амжилтын судалгаатай.

Зөвлөмж: Суралцагчдыг улсын болон олон улсын чанартай олимпиад, уралдаан, тэмцээнд оролцоулахад сургуулийн зүгээс дэмжих ажлыг “Оюутны зөвлөл”-ийн оролцоонд тулгуурлан зохион байгуулах

7.3.4. Олон улсад магадлан итгэмжлэгдсэн дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь

Тайлантай танилцахад: Багш-дуу хөгжим мэргэжлийн бакалаврын түвшний сургалтаас, ахисан түвшний сургалтад нийт 5 төгсөгч хамрагдаж байгаагаас төгссөн-3, суралцаж байгаа 2 магистрант байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал: Энэ үзүүлэлтэд зөвхөн СУИС-ийн ахисан түвшний сургалтад хамрагдсан суралцагчдын тоон үзүүлэлтийг оруулсан байна.

Зөвлөмж: Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх зорилгыг хэрэгжүүлэх үүднээс хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, дүгнэлт гаргуулдаг, сурталчилдаг байх. Мэдээллийг сүүлийн 3-5 жилээр оруулах.

7.4. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

7.4.1. Хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар олон нийтийг үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллээр тогтмол хангадаг байдал

Тайлантай танилцахад: 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн “Оюутны гарын авлага”-ыг тогтмол хэвлэж тараадаг болсон.

- Мэргэжил сурталчлах өдөрлөг,
- Тайлан тоглолтууд,
- Тэнхим сурталчлах өдөр,

Оюутны гарын авлагыг тогтмол хэвлэж тараадаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Боловсрол яармаг” үзэсгэлэнд оролцож, элсэгчээ татах үйл ажиллагааг эрчимтэй явуулдаг.
- Тайлан тоглолтуудад БУБ хөтөлбөрийн багш, оюутнууд тогтмол амжилттай оролцдог.

Дүгнэлт: Нийслэлчүүдийг өргөнөөр хамруулан зохион байгуулдаг “Гудамжны баяр”-т оюутнууд өөрсдийн авьяас чадварыг харуулах үүднээс идэвхтэй оролцож, хэвлэл мэдээллээр сурталчлуулдаг нь энэ хөтөлбөрийг сурталчлах боломжит хувилбар гэж үзэж байна.

7.4.2. Вeбсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа

Тайлантай танилцахад: 2011 оноос СУИС-ийн бүрэлдэхүүн бүх сургуулиуд UNICULTURE системд холбогдсон. Багш, оюутны ажиллуулдаг байнгын тогтмол ажиллагаатай 4 блогтой.

Уулзалтаар: Суралцагчид вэб сайт руу хэрэгцээтэй үед ханддаг бөгөөд түүнийг хэрэглээ болгох тал дээр суралцсаар байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- СУИС-ийн вэб сайт¹⁶ үйл ажиллагаа тогтмолжсон. Суралцагчдын хичээл сонголт, багшаа сонгох, дүн хэвлэх, багш, оюутны вэбэд сургалтын чанар, багшийн хичээлд анализ хийх асуулга тавигдаж, хичээлээ үнэлүүлэх боломжтой.
- БУБ хөтөлбөрийн хичээлүүдийн тестийг цахим хэлбэрт оруулсан.

Зөвлөмж: Зөвхөн СУИС-ХУС-ийн вэб сайтаас гадна бусад их дээд сургууль, мэргэжлийн байгууллагуудын вэб сайтуудтай холбоос хийх нь багш оюутнуудын цагийг хэмнэсэн, бодит мэдээллийг эх сурвалжаас нь олж авах боломжийг бүрдүүлж өгөх

Вэб хуудсанд хандсан хандалтын тоон мэдээлэл үзүүлэлтийг гаргаж, жил бүрээр харьцуулалт хийх

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

ШАЛГУУР 8. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖИЛТ

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

¹⁶ СУИС-ийн “Дүрэм журмын эмхэтгэл 2015” 306 хуудас

Үзүүлэлт нотолгоо:

8.1.1. Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуултыг хангах удирдлага, зохион байгуулалтын шийдэл, үр дүн

Тайлантай танилцахад: СУИС-ийн захирлын 17/1/05-ны өдрийн тушаалаар “Дотоод үйл ажиллагааны чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх” ажлын хэсгийг байгуулсан. UNICULTURE системээр оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авч эхэлсэн. Сургалтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 2011 онд дуу бичлэгийн студи, 2015 онд лекцийн “ танхим, хичээлийн 6 өрөөг тохижуулсан. Хөтөлбөрийн ерөнхий болон дэд хороог байгуулан ажиллуулж байна. Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийг хичээлийн 3 дугаар байрнаас хичээлийн 1 дүгээр байранд шилжүүлсэн зэрэг их сургуулийн хэмжээний удирдлага зохион байгуулалтын ажлыг тайлагнасан байна.

Бодит байдалтай танилцахад: Хөтөлбөрийн ерөнхий болон дэд хороодын хурлаар хэлэлцсэн хөтөлбөрт өөрчлөлт оруулах, сайжруулах чиглэлийн шийдвэрүүдийг үзүүлсэн бөгөөд UNICULTURE системд сэтгэл ханамжийн судалгааны асуулга, түүний үр дүнгийн боловсруулалтыг хадгалсан байв. Мөн СУИС-ийн чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх ажлын хэсгийг байгуулсан тушаал, ажлын төлөвлөгөөг танилцуулав.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж: Тухайн хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажууллын удирдлага, зохион байгуулалтын зураглал боловсруулж, албажуулах

8.1.2. Дотоод чанарын баталгаажуулалтын тогтсон бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ

Тайлантай танилцахад: Төгсөгчдийг мөшгөх судалгааг төслийн хүрээнд гүйцэтгэсэн бөгөөд цаашид уламжлал болгон хийхээр төлөвлөсөн байна. Судалгааны үр дүнг хөдөлмөр эрхлэлтийн байдлаар боловсруулж, дүгнэлт хийжээ. Сэтгэл ханамжийн судалгааг 2014, 2017 онуудад авсан тухай дурдсан байна.

Бодит байдалтай танилцахад: СУИС-ийн веб сайтад төгсөгчийн мөшгөх судалгааны талбартай, судалгааны үр дүнгийн боловсруулалттай, дүгнэлттэй байсан.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага: Төгсөгчийн мөшгөх судалгааны загвар, технологийн шийдэл, үр дүнгийн боловсруулалт нь бусад хөтөлбөрүүдэд нэвтрүүлэхүйц туршлага байна.

Анхаарах асуудал: Төгсөгчийн мөшгөх судалгааг цаашид тогтвортой үргэлжлүүлэх боломж тодорхойгүй, вебсайтад тухайн талбар байхгүй болсон. Тухайн хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажууллын цикл тогтворжоогүй, ажлын төлөвлөгөөгүй байна.

Зөвлөмж: Хөтөлбөрийн хүрээнд дотоод чанарын баталгаажууллын циклийг PDCA зарчмаар боловсруулан хэрэгжүүлэх, түүнийг дагасан төлөвлөгөө боловсруулан албажуулж, үр дүнг тооцохыг зөвлөмжилж байна.

8.1.3. Дотоод чанарын баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоо

Тайлантай танилцахад: 2017 онд төгсөгчдөөс болон ажил олгогчид, мэргэжлийн холбоодоос 2 удаа санал асуулга авсан. Үр дүнг боловсруулан СУИС-ийн СБЗГ-т танилцуулсан байна.

Бодит байдалтай танилцахад: Хөтөлбөрийн дэд хорооны гишүүнээр тухайн хөтөлбөрт тусгагдсан хичээлүүдийн харьяа тэнхмийн багш нар, төгсөгч, ажил олгогчид, мэргэжлийн байгууллага, оюутны төлөөллийг сонгон ажиллуулж байна.

Уулзалтаар: Төгсөгч, ажил олгогчидтой уулзахад хөтөлбөрийн үнэлгээ, шинжилгээ, сайжруулалтад янз бүрийн хэлбэрээр оролцдог. Тухайлбал, үзүүлэх хичээл, уулзалт, тоглолт, мэргэжил дээшлүүлэх сургалт зэргээр дамжуулан хөтөлбөрийнхөө агуулга, арга зүй, багтаамжийг сайжруулдаг талаар танилцуулав.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

8.1.4. Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг мэдээ баримтад тулгуурлан дүгнэж өөрийн үнэлгээг хийдэг байдал

Тайлантай танилцахад: Сэтгэл ханамжийн судалгааг асуулгын аргаар нэг бүлэг үзүүлэлтээр 2014 онд суралцагчдаас , 2017 онд төгсөгч, ажил олгогч, суралцагчдыг оролцуулан авсан тухайгаа тайлагнасан байна.

Бодит байдалтай танилцахад: UNICULTURE систем дэх сорилын чанарын үнэлгээ, сэтгэл ханамжийн судалгааны асуулга, үр дүнгийн боловсруулалт, багшийн журнал, төгсөгчдийн голч дүнгийн үзүүлэлт түүнд хийсэн дүгнэлтүүдээ танилцуулав.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

8.1.5. Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах зорилгоор судалгааны үр дүнг хөтөлбөрийн ахиц, дэвшилд системтэйгээр ашигласан байдал

Тайлантай танилцахад: 2017 онд авсан төгсөгчдийн судалгаагаар даралтат хөгжим тоглох чадвар, ардын хөгжмөөр хөгжмидөх арга барилд сургах чадварууд шаардлагатай түвшинд дөхсөн байна. Мэргэжлийн мэдээ материалыг гадаад хэлнээс орчуулан ашиглах, нотны программ дээр ажиллах, суралцагчдын нас сэтгэхүйн онцлог, хөгжлийн зүй тогтолд нийцсэн сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах, найрал дуу, хамтлаг, чуулгыг удирдан зохион байгуулах, хөгжмийн төрөл бүрийн үйл ажиллагааг зохион байгуулах, хөгжмийн зохиолын шинжилгээ судалгаа хийх ур чадварууд шаардлагатай түвшингөөс өндөр зөрүүтэй байгааг тодорхойлсон байна.

Уулзалтаар: Төгсөгч, ажил олгогчдийн судалгаанд үндэслэн “эрдэмтдийн семинар”, “Багш-хөгжил” сургалтуудыг хичээлээс гадуур зохион байгуулсан тухай танилцуулав.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Зөвлөмж: Сургалтын чанарыг хэмждэг олон төрлийн хэрэгслүүдийг тогтмол давтамжтайгаар ашиглах, судалгааны баримтууд, суралцагчдын сурлагын дүнд хамаарлын шинжилгээнүүдийг хийж хэвших, улмаар хөтөлбөрийн агуулга, арга зүй, орчинг сайжруулахдаа ашигладаг байхыг зөвлөө.

8.1.6. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд эргэх холбоо үүсгэх

Тайлантай танилцахад: 2012-2013 оны хичээлийн жилд МҮСХГ-аас стандартчилалд оруулах баг ажиллаж, хөтөлбөрийн талаар сонирхогч, оролцогч байгууллагын төлөөллөөс судалгаа авсан. Тэднээс ирүүлсэн 2 саналыг үндэслэн тухайн хөтөлбөрт засвар оруулснаа тайлагнав.

Бодит байдалтай танилцахад: 2017 оны төгсөгчийн судалгаа, ажил олгогч, төгсөгчидтэй хийсэн уулзалт, вебсайт дахь төгсөгчдийн судалгааны талбар зэрэг нь эргэх холбоог хэрэгжүүлж байгааг илтгэнэ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

8.2. Хөтөлбөр нь олон улсын болон үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлж, хөндлөнгийн үнэлгээ хийлгэдэг байна.

8.2.1. Магадлан итгэмжлэл, хөндлөнгийн үнэлгээ хийлгэсэн байдал

Тайлантай танилцахад: МҮСХГ-аар хөндлөнгийн үнэлгээ хийлгэсэн, НБГ, БСШУЯ тай хамтран хөгжмийн багш нарт мэргэжил дээшлүүлэх сургалт хийх явцдаа асуулга, ярилцлага, ажиглалтын аргаар судалдаг тухай тусгасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

8.2.2. Гарсан үр дүн, ахиц дэвшил

Тайлантай танилцахад: 2014, 2017 оны судалгаагаар хөтөлбөрийн үр дүн ахиц дэвшилтэй байгааг SWOT шинжилгээний аргаар харуулжээ.

Уулзалтаар: Хөтөлбөр хэрэгжүүлэгчид чанарын баталгаажуулал хариуцан ажилладаг бие даасан мэргэжилтэнтэй байх, цаашид сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч хэвших, мэргэжлийн салбар дахь нөлөөллийн үнэлгээг баталгаажуулахад анхаарч ажиллах саналтай байгаагаа танилцуулав.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж: Хөтөлбөрийн ахиц дэвшлийн тогтмол үзүүлэлт, нарийчилсан шалгуурыг боловсруулан албажуулж хэрэглээнд оруулахыг санал болгож байна.

8-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН

ДҮГНЭЛТ:

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1.	Хөтөлбөрийн төлөвлөлт	9	-	-	
2	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	10			
3	Хөтөлбөрийн удирдлага	25			
4	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	17	1		Оюутны байгууллагын зүгээс санхүүгийн зарцуулалтаа ил тод тайлагнах тал дээр анхаарч ажиллах
5	Багшийн үйл ажиллагаа	20			
6	Сургалтын үйл ажиллагаа	15	1	-	6.2.5 Багш, урлагийн боловсрол” хөтөлбөрийн сургалтын арга зүйн нэгдсэн тогтолцоог тодорхойлж, арга зүйн заавар, загварууд бүрэн бус.
7	Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө	12			
8	Чанарын үнэлгээ, баталгаажилт	8	2	-	8.1.2 Сургалтын чанарын баталгаажууллын цикл тодорхойгүй, чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө хэт товч. 8.1.5 Сургалтын чанарыг хэмждэг олон төрлийн хэрэгслүүдийг тогтмол давтамжтайгаар ашиглах, судалгааны баримтууд, суралцагчдын сурлагын дүнд хамаарлын шинжилгээнүүдийг хийж эхэлсэн ч хэвшил болоогүй.
		125	4		

ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ЭЦСИЙН ДҮГНЭЛТ:

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургуулийн “Багш, урлагийн боловсрол” бакалаврын сургалтын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг Боловсрол чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/Б.Одончимэг/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Ц.Шаравцэрэн/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Т.Олоннэмэх/

V. Оролцогчдын нэрс

I. Ярилцлагад оролцсон багш нарын нэрс.

	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1	Ч.Оюунбилэг	Зөвлөх багш	магистр	37	Сурган, заах арга зүйн багш
2	С.Баасандулам	Тэнхимийн эрхлэгч	магистр	25	Сурган сэтгэл судлал
3	Л.Баяраа	Багш	магистр	9	Найрал дуу заах, удирдах арга зүй
4	Г.Оюунтуяа	Багш	магистр	23	Төгөлдөр хуур
5	Ж.Ууганцэцэг	Багш	магистр	11	Төгөлдөр хуур, заах арга зүйн багш

II. Оюутны нэр

№	Оюутны нэрс	Курс
1	А.Ууганзаяа	II
2	А.Жавхлан	II
3	О.Бямбабаатар	II
4	Б.Ханддулам	II
5	Д.Өлзийжаргал	III
6	М.Жигмэдсүрэн	III
7	Ж.Энхбаяр	III
8	Б.Амарзаяа	IV
9	П.Гантуяа	IV
10	Г.Наранзул	IV
11	Ч.Энхчулуун	IV
12	Б.Дарьсүрэн	II

III. Ажил олгогч

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	Б.Амартүвшин	ОУ-ын хөтөлбөртэй “Шинэ эрин” сургууль	Захирал
2	С.Хүрэлбаатар	БЗД 127 дугаар сургууль	Захирал
3	Н.Цэрэндолгор	Төрийн бус өмчийн Шинэ үе сургууль	Захирал
4	Ц.Байгаль	СХД 104 дүгээр цэцэрлэг	Эрхлэгч
5	Д. Мөнхнасан	ОУ-ын IOV Mongolia	Захирал

IV. Төгсөгчид

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	Ш.Ариунчимэг	2014	ОУ-ын хөтөлбөртэй Шинэ эрин сургууль	Хөгжмийн багш
2	Х.Эрдэнэбаатар	2015	Төрийн бус өмчийн Шинэ үе сургууль	Хөгжмийн багш
3	Л.Эрдэнэбилэг	2009	СБД Харааны бэрхшээлтэй хүүхдийн 116 дугаар сургууль	Хөгжмийн багш
4	Ц.Ялалт	2007	Өвөр монголын урлагийн их сургууль	Хөгжмийн багш
5	У.Ууганцэцэг	2016	84-р дунд сургууль	Хөгжмийн багш
6	Б.Байгалмаа	2014	СУИС-ийн Бадмаараг ахлах сургууль	Концертмейстр
7	А.Анардарь	2017	Muse art сургалтын төв	Хөгжмийн багш
8	Ж.Болортуяа	2016	ЭОЦ сургууль	Хөгжмийн багш
9	Х.Эрдэнэбаатар	2015	Шинэ үе дунд сургууль	Хөгжмийн багш
10				Хөгжмийн багш

VI. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛЬ
ХӨГЖМИЙН УРЛАГИЙН СУРГУУЛЬ

15140 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 26, Утас: 32 88 45, Факс: (976-11) 32 52 05

2018.10.24 № 01/239

танай _____-ны № _____-т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

Тус сургуулийн Багш, урлагийн боловсрол хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шинжээчдийн гаргасан тайлантай танилцаж санал нэгтэй байгаагаа илэрхийлье.



ЗАХИРАЛ

Г.ГАНЦЭЦЭГ

My doc/alban toot